



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО,
ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ҮР ДҮН

АУДИТЫН КОД: БНА-2021/14-4-ШТА-ГА

ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ОРОН НУТГИЙН ОНЦЛОГТ НИЙЦСЭН
ТӨЛӨВЛӨГӨӨГҮЙГЭЭС СТРАТЕГИЙН ХҮНСНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЭЭГҮЙ
БАЙНА.

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга**
бөгөөд тэргүүлэх аудитор Б.Мөнхбат
Утас: 70442584 цахим хуудас: munkhbatb@audit.gov.mn
Аудитын менежер А.Цээням
Утас: 70442424 цахим хуудас: tseenyma@audit.gov.mn
Ахлах аудитор Б.Азбаяр
Утас: 99061429 цахим хуудас: azbayarb@audit.gov.mn
Аудитор Ж.Өсөхбаяр
Утас: 99890393 цахим хуудас: usukhbayari@audit.gov.mn



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 4/28

Номгон

Г Аудитын тайланг баталгаажуулах тухай Г

Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн А/207 дугаар тушаалаар батлагдсан “Эрх шилжүүлэх” тухай тушаалын 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 18.9 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Гүйцэтгэлийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг ахлах аудитор /Б.Азбаяр/-д үүрэг болгосугай.

3. Аудитын тайланг аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Мал эмнэлгийн газар, Эрүүл мэндийн газарт тус тус хүргүүлэхийг ахлах аудитор /Б.Азбаяр/-д даалгасугай.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч биелэлтийг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Засаг дарга /Д.Мөнхсайхан/, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга /Н.Бямбадорж/, Эрүүл мэндийн газрын даргыг түр орлон гүйцэтгэгч /Н.Энхжаргал/, Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Баттөр/, Мал эмнэлгийн газрын дарга /Л.Оюун-Эрдэнэ/ нарт тус тус зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон байгууллагын архивд хүлээлгэн өгөхийг ахлах аудитор /Б.Азбаяр/, аудитор /Ж.Өсөхбаяр/ нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /А.Цээням/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

Б. МӨНХБАТ

2021 Тушаал

005010034

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны 11 дүгээр
сарын 04-ний өдрийн А/23 тоот тушаалын хавсралт

АУДИТААР ӨГСӨН АЛБАН ШААРДЛАГЫН ЖАГСААЛТ

№	Төлбөр, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Зөрчил хариуцах	
		Албан шаардлага	Байгууллага	Албан тушаалтан
А	1	3	4	5
1	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторид ашиглаж байгаа 43 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмжүүдийг 2019 онд итгэмжлэлд хамрагдсанаас хойш шалгалт тохируулга хийлгээгүй, багаж тоног төхөөрөмжийн баталгааны хугацаанд байгаа эсэхэд хяналт хэрэгжүүлэхгүй байгаа нь Хэмжил зүйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтыг зөрчсөн байна.	-	Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газар	Мал эмнэлгийн газрын дарга Л.Оюун-Эрдэнэ, Лабораторийн эрхлэгч Б.Баярмаа
ДҮН		-	-	-

_____оОо_____

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	3
БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ОРОН НУТАГ ӨӨРИЙН ОНЦЛОГТ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ҮР ДҮНГ ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ИЛЭРХИЙЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.	5
1.1. <i>Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулаагүй, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тайлагнаагүйгээс үр дүнг дүгнэх боломжгүй байна.</i>	5
1.2. <i>Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоо хангалтгүй байна.</i>	10
1.3. <i>Баянхонгор аймгийн хэмжээний стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлээгүй, зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн нь импортын бүрэн хамааралтай байна.</i>	15
БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ОНОВЧТОЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШИГ БОДИТОЙ ГАРАХГҮЙ БАЙНА.	36
2.1. <i>Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө, хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй байна.</i> .	36
2.2. <i>Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг оновчтой хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгийн үр ашиг бодитой гарахгүй байна.</i>	37
ДҮГНЭЛТ:	39
ЗӨВЛӨМЖ:	40
ҮАГ-ЫН АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:	42

Товчилсон үгийн тайлбар

УИХ	Улсын Их Хурал
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУЕА	Монгол Улсын ерөнхий аудитор
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлийн хэлтэс
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
МЭГ	Мал эмнэлгийн газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх Аудитын зорилт Аудитын хамарсан хүрээ Аудитын хязгаарлалт Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2020 оны 5 дугаар тогтоол, МУЕА-ын 2021 оны А/28 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийв. Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд: ➤ Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх. ➤ Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй эсэх. Аудитад хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг зохион байгуулан, бүх түвшинд хэрэгжилтийг хангуулж, хяналт тавих, мэдээллээр хангах чиг үүрэгтэй Баянхонгор аймгийн тусгай болон төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудал эрхэлсэн байгууллагууд, төр, хувийн өмчийн лабораториуд, хүнсний сүлжээний бүх үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэний аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамруулан холбогдох баримт бичиг, үйл ажиллагааны үр дүн, бусад материалуудаас авсан мэдээ, тайлан бусад материалд тулгуурлан гүйцэтгэлийн аудитыг хийв. Аудитад 2016-2020 оныг хамруулсан бөгөөд бусад тайлант онуудыг хамруулаагүй болно. Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУБ (INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС 100, 300, 3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020, “Төрийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим” MNS 6817-7:2020 “Төрийн аудит, гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах бүх төрлийн нотлох зүйлсийг цуглуулах, нягтлан шалгах, баримтад дурдсан мэдээлэлд судалгаа, шинжилгээ харьцуулалт, тулган баталгаажуулалт хийж, үр дүнг тооцох арга зүйг ашиглав. Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгөтэй холбоотой хууль, эрх зүйн актыг судлах, холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, мэдээлэл, тодруулга авах, асуудал эрхэлсэн байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, судалгаа, тайланг судалж, дүнг нэгтгэн аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав. Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цэням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Ж.Өсөхбаяр төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.
---	---

**Хүндрэл
бэрхшээл**

Аудитын талбарын үе шатны ажлыг 2021 оны 09 дүгээр сарын 13-наас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад дэд тайлангийн төслийн бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 11 дүгээр сарын 04-ны өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

1. Ковид цар тахал гарч зарим шалгагдагч байгууллагын холбогдох албан хаагчид тусгаарлалтад орсон.
2. Аудитын багийн гишүүн Ковид-19 өвчний халдвар авч ажлын хуваарь төлөвлөсний дагуу хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүссэн.

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

БҮЛЭГ 1. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТАЛААР ТӨРӨӨС БАРИМТЛАХ БОДЛОГЫГ ОРОН НУТАГ ӨӨРИЙН ОНЦЛОГТ УЯЛДУУЛЖ ТӨЛӨВЛӨЖ, ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ҮР ДҮНГ ТООН ҮЗҮҮЛЭЛТЭЭР ИЛЭРХИЙЛЭХ БОЛОМЖГҮЙ БАЙНА.

1.1. Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн онцлогт нийцүүлэн боловсруулаагүй, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, тайлагнаагүйгээс үр дүнг дүгнэх боломжгүй байна.

1.1.1. Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.2-т “Эрүүл, аюулгүй орчинд амьдрах” гэж тодорхойлсны дагуу Хүнсний аюулгүй байдлын чиглэлээр Монгол улсын УИХ, Засгийн газар, болон орон нутгийн түвшинд эрх зүйн бодлогын баримт бичгийг боловсруулж ирсэн байна. Тухайлбал “Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, “Алсын хараа 2050”, “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого” зэрэг урт болон дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүд боловсруулахдаа хүнсний хангамж, хүртээмж, хяналт, баталгаажуулалт, био аюулгүй байдал, техникийн шаардлага стандарт гэх мэт хүнсний аюулгүй байдлыг олон талаас нь авч үзэн бодлогын баримт бичигт тусгажээ.

Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд хүнсний хангамж, тогтвортой хүртээмжтэй байдал, шим тэжээллэг байдал, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх, үндсэн зарчмуудыг тусгаж өгсөн бөгөөд дээрх үзэл баримтлалын хүрээнд Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тусгаж, ирсэн байна.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлан Засгийн газрын дунд хугацааны хөтөлбөрийг боловсруулан түүний биелэлтийг жил бүр эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган үйл ажиллагааг зохион байгуулжээ.

Аудитаар дээрх урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичигт туссан хүнсний талаар төрөөс баримтлах бодлогын зорилго зорилтуудыг орон нутагт хэрхэн төлөвлөж, хэрэгжүүлж, байгаа талаар судлав.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, түүний биелэлтийг гаргуулан авахад Баянхонгор аймгийн 2016-2020 оны аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн гуравдугаар бүлэгт Хүнс, хөдөө аж ахуй,

байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогыг тусгасан байна. Баянхонгор аймаг нь 2016-2020 онд “Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийг тогтвортой нэмэгдүүлэх зарчим баримталж, таваарлаг мал сүрэгтэй, эрчимжсэн газар тариаланг хөгжүүлж, иргэдийнхээ орлогыг нэмэгдүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлж хөдөө аж ахуй, байгаль орчны чиглэлээр нийт 28 зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Аудитын илрүүлэлт

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж батлуулахдаа тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг бүсчилсэн хөгжлийн бодлоготой хэрхэн уялдсан талаар тусгаагүй, байгаа нь 2015.11.26-нд батлагдсан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15.1¹-д дэх заалтыг хангасан эсэх нь тодорхойгүй байна. Мөн аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны 2020 оны хөтөлбөрийн биелэлтийг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэн дүгнэж, баталгаажуулаагүй байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн, 15.4² дэх заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг гаргахдаа Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлтэй уялдуулан арга хэмжээ тус бүрээр гаргаж Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.10.4³ дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 28 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд биелэлтийг тооцохдоо 24 үйл ажиллагаа нь бүрэн хэрэгжсэн 3 төсөл, арга хэмжээ нь 70 хувийн гүйцэтгэлтэй, 1 төсөл арга хэмжээг хэрэгжилт тооцох боломжгүй нийт 96,66 хувьтай гэж 2020 оны байдлаар ХХААГ-ын гаргасан байна.

Аудитын илрүүлэлт

Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 91-д заасан “Иргэдээ аймгийнхаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн төмс хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах “Органик хүнс” төсөл хэрэгжүүлнэ.” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг гаргахдаа “Органик хүнс аймгийн дэд хөтөлбөрийг газрын даргаар батлуулж 18 зорилтын хүрээнд хэрэгжүүлж байна” гэж гаргасан боловч тус дэд хөтөлбөрийг ХХААГ-ын дарга баталж хэрэгжүүлээгүй байхад буруу тайлагнасан байна.

¹ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр нь бүсчилсэн хөгжлийн бодлого, аймаг, нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилттой уялдсан байх ба тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн дунд хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын чиглэл, түүнд хүрэх зорилго, зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээ, төсөв, санхүүгийн эх үүсвэр, шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байна.

² Тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр хэлэлцэн дүгнэнэ

³ Засаг дарга сум, дүүргийн түвшинд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдааг хангах, үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд хяналт тавих

Иймд хөтөлбөрийн үйл ажиллагааны тайланг хэлтэс, агентлагаар гаргуулан авахдаа хийж хэрэгжүүлсэн ажлыг баримтаар гаргуулан авч үнэлсний үндсэн дээр биелэлтийг хүлээн авах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.2. Баянхонгор аймагт хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа стандартыг өнөөгийн хэрэгцээ шаардлагад нийсэн эсэхийг стандартыг хэрэгжилтийг хангуулах гол чиг үүрэг бүхий аймгийн Стандарт хэмжилзүйн хэлтэс болон стандартын хэрэглэгч МХГ болон МЭГ-ын лабораториудаас үндэсний стандарт өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа эсэх талаар асуулга авч хэрэглэгдэж буй стандартуудад судалгаа хийлээ.

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/302 тоот тушаалаар Баянхонгор аймгийн мэргэжлийн хяналтын газрын сорилтын лабораторийн итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтод Хүнсний бүтээгдэхүүний, ахуйн бүтээгдэхүүн, физик, хими хор судлалын сорилт, нян судлалын шинжилгээ, гэх мэт гүйцэтгэж буй сорилтын төрлөөр нийт давхардсан тоогоор 323 стандартын жагсаалтыг гаргаж итгэмжлэлийн хүрээний тодорхойлолтыг баталсан байна.

Мөн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/317 тоот тушаалаар Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторид итгэмжлэл хийсэн бөгөөд Нян судлал, ийлдэс судлал, ариун цэвэр, шимэгч судлалын сорилтын төрлөөр нийт 68 стандартыг итгэмжлэлийн тодорхойлолтод баталж өгсөн байна.

Дээрх стандартууд нь үйл ажиллагаанд мөрдөхөд хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа талаар Баянхонгор аймагт үйл ажиллагаа явуулж буй 2 итгэмжлэгдсэн лабораториос тодруулахад хүндрэл бэрхшээл, хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа гэсэн тайлбарыг өгсөн болно.

1.1.3. Монгол улсын их хурлын болон Засгийн газрын тогтоолоор батлагдсан үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг Баянхонгор аймагт дараах үндэсний хөтөлбөр хэрэгжиж байна.

Хүснэгт № 1. Үндэсний хөтөлбөрийн жагсаалт

№	Хэрэгжиж буй салбар	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан шийдвэр, он	Хэрэгжих он
1	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2019 оны №156	2019-2021
2	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Эрүүл хүнс-эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2019 оны №52	2019-2023

№	Хэрэгжиж буй салбар	Хөтөлбөрийн нэр	Батлагдсан шийдвэр, он	Хэрэгжих он
3	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2017 оны №223	2018-2022
4	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2017 оны №278	2018-2023
5	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-3	Засгийн газрын 2019 оны №362	2019-2024
6	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны №12	2018-2021
7	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Монгол мал хөтөлбөр	Улсын их хурлын 2010 оны №23	2018-2020 2021-2024
8	Хүнс, хөдөө аж ахуйн салбар	Сав баглаа боодол хөтөлбөр	Засгийн газрын 2016 оны №287	2017-2021
9	Эрүүл мэнд	Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2015 оны №447	2016-2020
10	Үйлдвэрлэл, дэд бүтэц, эрчим хүч	Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр	Засгийн газрын 2018 оны №36	2018-2021
11	Байгаль Орчин	Ус үндэсний хөтөлбөр	Улсын их хурлын 2010 оны №24	2010-2021

Дээрх хөтөлбөрүүдээс биелэлтийн тайланг ирүүлсэн хөтөлбөр арга хэмжээний хувьд үр дүн гарсан, хүнсний хангамжид хувь нэмэр оруулсан гэж үзсэн арга хэмжээний үр дүнг 2020 оны түвшинд авч үзэн дурдвал:

1. Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр /2019-2021/

Тус хөтөлбөрийн зорилго нь Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих замаар бүтээмжийг өсгөх, зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ажлын байр нэмэгдүүлэх бөгөөд тус зорилгын хүрээнд 6 зорилтыг дэвшүүлж ажилласан.

Гол үр дүн: 2020 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжүүлэх 6 зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг 100 хувь гэж дүгнэсэн байна. Хөтөлбөрийн үр дүнд “Үйлдвэрлэл үйлчилгээний ажилсаг төв”-өөр дамжуулан 13 чиглэлээр 56 иргэн, аж ахуйн нэгжид 815,0 сая төгрөг олгосноор, шинээр 164 ажлын байр бий болсон.

2. Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр /2018-2022/

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь “жимс, жимсгэнийн нэр төрөл, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн чацарганын тариалалтыг 10 мянган га, бусад төрлийн жимс, жимсгэнийн тариалалтыг 2 мянган га талбайд хүргэж, хүн амыг экологийн цэвэр, амин дэм бүхий жимс, жимсгэнээр тогтвортой хангах, импортыг бууруулах, өрсөлдөх чадварыг сайжруулан экспортын орлогыг нэмэгдүүлэх” гэж тодорхойлсон байна. 2020 оны жилийн эцсийн биелэлтээр 4 зорилт тавьж ажилласны 1-3 дахь зорилтууд 100 хувь, 4 дэх зорилтыг 70 хувь гэж дүгнэсэн байна.

Гол үр дүн: Жимс жимсгэнэ дэд хөтөлбөрийн хүрээнд энэ онд шинээр 5,5 га талбайд чацаргана, үхрийн нүд нэмж тариалан өмнөх оны тариалсан мод суулгацыг танаж тайран арчилгаа усалгааг бүрэн хийснээр 11 хоршоо, аж ахуйн нэгж, 121 иргэн нийт 293,3 га талбайд жимсний мод суулгац тарьж 355,9 тн ургац хураан авсан байна.

3. Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр /2018-2023/

Тухайн хөтөлбөр нийт 4 зорилт дэвшүүлсэн бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг 1,4 дүгээр зорилтыг 100 хувь, 2 дугаар зорилтыг 96 хувь 3 дугаар зорилтыг 70 хувьтай нийт биелэлтийн дундаж хувийг 91 хувьтай дүгнэсэн байна.

Гол үр дүн: Нийт 17 сумын 5058 м.кв талбай бүхий 81 өвөл, зуны болон нарны энергиэр халдаг хүлэмжид нарийн ногоо, жимс жимсгэнэ тариалж 78 тн ургац хураан авсан.

4. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-3 /2019-2023/

Тус хөтөлбөрийн хүрээнд үндсэн 4 зорилт тавьж ажилласан бөгөөд 2020 оны хөтөлбөрийн биелэлтийг дүгнэхдээ зорилтууд 80-88 хувьд үнэлэгдэж нийт 84,6 хувьтай дүгнэгдсэн байна.

Гол үр дүн: Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Хөдөөгийн хөгжил төслөөс Өлзийт сумын Наянбулаг тал хоршоонд 11 сая төгрөгийн өртөг бүхий 10 нэр төрлийн сүү сүүн бүтээгдэхүүн боловсруулах иж бүрдэл тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй олгон дэмжлэг үзүүлж, 17 тн сүү боловсруулсан байна.

5. Монгол мал хөтөлбөр

Монгол мал хөтөлбөрийн хүрээнд 36 зорилт бүхий дэд хөтөлбөрийг хэрэгжүүлж, 2020 оны байдлаар 89,4 хувьтай үнэлэгдсэн байна.

Гол үр дүн: Аймгийн хэмжээнд ашиг шимийн түвшний судалгааг Монгол үүлдрийн малын ашиг шимийн стандарттай харьцуулахад Баянбулаг хонины амьдын жин 3-5 кг-аар илүү, Залаажинст-Эдрэн үүлдрийн ямаа, Бөмбөгөрийн улаан омгийн ямааны ноолуурын гарц 50-70 гр-р тус тус илүү, Ламын гэгээний улаан тэмээний сүүний гарц 300-500 мл-ээр, ноосны гарц 200 гр-аар, амьдын жин 50-80 кг-аар тус тус илүү байгаа нь бусад сумдад үржүүлж буй нутгийн Монгол үүлдрийн малын ашиг шимийг сайжруулах боломж байгааг дүгнэсэн.

6. Сав баглаа боодол хөтөлбөр

Орон нутаг болон төсөл хөтөлбөрөөс олгогдсон санхүүжилт хийгдээгүй, үр дүнг тодорхойлоогүй байна.

7. Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр

Энэхүү хөтөлбөр нь Хоол тэжээлийн талаар хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангаснаар хоол тэжээлээс хамааралтай өвчлөл буурна гэж тодорхойлсон байна. Тус хөтөлбөрийг 2020 онд 87,9 хувьтай гэж дүгнэсэн байна.

Гол үр дүн: Зөв зохистой хооллолт, хоол хүнсээр дамжих өвчлөлөөс сэргийлэх, ажлыг зохион байгуулсан бөгөөд 2800 иргэнд мэдээлэл, сургалт сурталчилгаанд хамрагдсан

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг гаргахдаа хөтөлбөрийн хэрэгжилтийг шалгах үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүдээр хүрсэн түвшнийг тооцож гаргаагүй байгаа нь хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн үйл ажиллагаа нь үр дүнтэй, дэвшүүлсэн зорилтыг хангаж байгаа эсэхийг тоон үзүүлэлтээр хэмжих боломжгүй байна.

Иймд Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг орон нутгийн онцлогт тохируулан, хөтөлбөрийн үр дүнг тооцох шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг тооцож хэрэгжилтийг бодитой, тоо мэдээ, судалгаанд үндэслэн гаргах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

1.1.4. Хүнсний харилцаанд оролцож буй талуудаас эрх зүйн зохицуулалтад зөрчилтэй, хэрэгжих явцад хүндрэл бэрхшээлтэй асуудал байгаа талаар асуулга авахад дараах хуулийн зөрчилдөөнтэй асуудал байна. Үүнд:

Аудитын илрүүлэлт

1. Хүнсний тухай хуулийн 6.2-д “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан байхад уг журам өнөөг хүртэл батлагдаагүй.
2. Аймгийн МХГ-ын лаборатори, МЭГ-ын лабораторийн орон тоог батлахдаа 10 орон тоотой байхаар зохион байгуулагдсан байхад өнөөгийн нөхцөлд тус бүр 5 орон тоогоор үйл ажиллагаа явуулж байна.
3. Үндэсний хэмжээний хөтөлбөр батлагдаж ирдэг боловч хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүжилтийн асуудал орон нутагт батдагдаж ирдэггүй, орон нутгийн төсөвт хөтөлбөр хэрэгжүүлэх зардал төсвийн хүрэлцээ боломж муу байгаагаас батлагдаагүй.

Мөн Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 17.1⁴-дэх хэсэгт заасан улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн жагсаалтыг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор батлахдаа Улаанбаатар, Чойбалсан, Дархан, Эрдэнэт, Ховд, Даланзадгад хотын ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжаас бусад аймгуудын ус хангамжийн эх үүсвэрийг оруулаагүй байгаа нь хүн амын амь, нас эрүүл мэндэд аюул учирч үндэсний аюулгүй байдал алдагдаж болзошгүй эрсдэлтэй байна.

Иймд дээрх хүндрэл бэрхшээл, хууль эрх зүйн зөрчлүүд нь хүнсний аюулгүй байдал алдагдах эрсдэлтэй нөхцөл байдал үүсгэж болзошгүй байгааг харгалзан холбогдох газраар шийдвэрлүүлэх зөвлөмж хүргүүлэх саналыг Үндэсний аудитын газрын аудитын Гуравдугаар газарт хүргүүлэв.

1.2. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн бодлогыг тодорхойлоход мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын оролцоо хангалтгүй байна.

1.2.1. Баянхонгор аймагт хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн чиг үүрэг бүхий байгууллагуудаас гадна “Баянхонгор аймаг дахь “Хүнсчдийн холбоо” төрийн бус байгууллага үйл ажиллагааг явуулж байна.

Баянхонгор аймаг дахь Хүнсчдийн холбоонд аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа Талх нарийн боовны үйлдвэр, хиамны үйлдвэр, хэрчсэн гурилын

⁴ Улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтыг дотоодын цэрэг гүйцэтгэж, бусад ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байна.

үйлдвэр гэх мэт хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын гишүүнчлэлээс бүрдсэн төрийн бус байгууллага юм.

Хүнсний аюулгүй байдлыг хангах, бодлогын чиг үүргийг төрийн нэрийн өмнөөс хэрэгжүүлж төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагын хоорондын уялдаа холбоог авч үзэв.

Аудитын илрүүлэлт

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нь аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд хүнсний аюулгүй байдлын талаар төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах чиг үүргийг хэрэгжүүлж, уялдаа холбоог хангаж ажиллахаар албан тушаалтны ажлын байрны тодорхойлолтод тусгасан байхад тус чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллахгүй байна.

Аудитаар хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл эрхлэгчийн төлөөлөл, Баянхонгор аймгийн Хүнсчдийн холбооны тэргүүнтэй ярилцлага хийхэд “Үйлдвэрлэл эрхлэхэд төрийн байгууллагаас дэмжлэг байдаггүй, бид бүгд өөрсдөө үйл ажиллагааг бага багаар өргөтгөж сайжруулж өдий зэрэгт хүргэж байгаа. Төрөөс дэмжлэг авах гэж хэд хэдэн удаа хөөцөлдөж үзсэн боловч бүтээгүй, Харин арилжааны банкны зээлээр бидний үйл ажиллагаа урагшилж байна. Хүнсний салбар бол орхигдсон салбар гэж хэлж болно. Миний хувьд гурилан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхэлж байгаа, одоо үйлдвэрлэлийг бүрэн автоматжуулах зорилт дэвшүүлж ажиллаж байна. Олон улсын үзэсгэлэнд өөрийн зардлаар оролцсон тэнд манай чиглэлийн үйлдвэрлэлийн бүтэн шугам танилцуулсан бөгөөд түүний өртөг зардлыг хүчрэхгүй тул хэд дахин жижгэрүүлсэн хувилбарыг БНХАУ-д өөрийн биеэр очин захиалж үйлдвэрлэлдээ нэвтрүүлж байна. Мөн хүнсний технологич Герман улсаас авчирч технологи заалгуулсан энэ бүхэнд биднээс өөрөөс зардал гарч байгаа” гэсэн тайлбарыг өгч байв.

Мөн Баянхонгор аймагт хүнсний чиглэлийн үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэгчээс төрийн дэмжлэг оролцооны талаар тодруулахад: “Төр оролцохдоо татвар хураах гэж татварын байгууллагаас, стандарт шалгах гэж МХГ-аас ирж шалгаж байна. Бид хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргасан боловч хүссэн зээлийн 30 хувьд шийдвэрлэж өгсөн. Энэ нь үйлдвэрлэлд бол зөвхөн бэлтгэл ажил хийх л хөрөнгө болсон. Дараа нь бараг тухайн зээл нь биднийг өрийн дарамтад оруулах хэмжээнд хүргэсэн” гэсэн тайлбар өгөв.

Гэвч аймгийн Засаг даргын бодлогын хэлтэс “ЖДҮ, өрхийн бизнесийг хөгжүүлэхэд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татах, хоршоо биржийн хөгжлийг тогтворжуулахад өрсөлдөх чадварыг сайжруулах, зах зээлийг өргөжүүлэхэд бодлогын

хэрэгжилтийг зохион байгуулах”, “Холбогдох судалгаа, мэдээллийн сангийн үндсэн дээр салбарын хөгжлийн тодорхойлж, бодлого боловсруулан төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах” гэж албан тушаалтны ажлын чиг үүрэгт тусгасан атлаа хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Баянхонгор аймаг дахь Хүнсчдийн холбооноос ирүүлсэн санал:

Баянхонгор аймаг дахь Хүнсчдийн холбооноос хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулахад орон нутгаас зохицуулалт хэрэгтэй байгаа талаар дурдаж дараах саналыг ирүүлэв. Үүнд:

1. Орон нутгаас олгож буй зээл тусламжийг хүн амын бодлогод уялдуулж ямар салбарт олгохоо тодорхой болгох ЖДҮ-ийн дэмжих сангийн зээлийг хэрэгжиж болох цаашид өсөх боломжтой бизнесийг хүссэн хэмжээнд дэмжих.
2. Хотоос ирж байгаа бараа бүтээгдэхүүн дээр хяналт шалгалт хийх.
3. Үйлдвэрлэл хөгжүүлэх хөтөлбөр дээр өрхөөс хүнс үйлдвэрлэж, борлуулах байдлыг хориглох.
4. Тусгай зөвшөөрөл олгох журмаар орон нутгийн үйлдвэрлэгчдийг, бараа бүтээгдэхүүнийг, түлхүү зарж борлуулах заалт оруулах.
5. Орон нутгийн үйлдвэрлэгч нараа дэмжих зорилгоор гадны үйлдвэрлэгч нараас дотоодын зах зээлээ хамгаалах.

Дээрх ирүүлсэн саналыг аймгийн Засаг даргад уламжилж, хүнсний салбарын үйлдвэрлэгчдийн тавьсан хүсэлтийг харгалзан үзэж бодлого чиглэлдээ тусгахыг зөвлөв.

Мөн төрийн болон төрийн бус байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулан, бодлогын баримт бичгийг боловсруулахдаа мэргэжлийн байгууллага холбоодын саналыг авч, тал бүрийн оролцоотой шийдвэрлэж ажиллахыг аймгийн Засаг даргад зөвлөмжөөр хүргүүлэв.

1.2.2. Орон нутгийн түвшинд хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд аймгийн Засаг дарга, түүний ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс, аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Мал эмнэлгийн газрууд бодлого төлөвлөлт болон хяналтын чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Аудитаар дээрх байгууллагуудын хүнс, хариуцсан мэргэжилтэн, улсын байцаагчид албан тушаалтнуудын ажлын байрны тодорхойлолтуудыг авч албан тушаалын зорилт болон гүйцэтгэх чиг үүргийг авч дүн шинжилгээ хийв.

Засгийн газрын 2003 оны 7 дугаар тогтоолоор “Улсын мэргэжлийн хяналтын албаны нийтлэг дүрэм”-ийг баталсан бөгөөд уг дүрмийн 2.22-д Хүнсний үйлдвэрлэл, технологийн хяналт” -ын чиглэлийг тодорхойлсон байна.

Мэргэжлийн хяналтын байгууллагын Улсын байцаагчийн бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалт хийх, хяналт шалгалтын стандартын дагуу хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаж байна.

Аудитын илрүүлэлт

Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-ийн Хүнс, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтэн болон аймгийн ХХААГ-ын Хүнсний үйлдвэрлэл, нийтийн хоол худалдаа, үйлчилгээний асуудал хариуцсан мэргэжилтний ажлын зарим чиг үүрэг нь давхардсан байна.

Тухайлбал: ХОХБТХ-ийн Хүнс, худалдаа, үйлдвэрлэл үйлчилгээний бодлого хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтод заасан зорилт 2.4-д “Хүн амын хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, нөөц бүрдүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах”, 2.8-д “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдалд мэргэжлийн байгууллагатай хамтран хяналт тавих, шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх, норм стандартыг мөрдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг чиглүүлэх”-д гэсэн 2 чиг үүрэг нь үг, өгүүлбэрийн хувьд яг ижил, бодлогын болон хүнсний аюулгүй байдлын хүрээнд хэрэгжүүлэх чиг үүрэг нь ерөнхий агуулгаар давхардсан гэж үзэхээр байна.

Иймд аймгийн Засаг даргын бодлогын хүрээнд дээрх албан тушаалтнуудын чиг үүргийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулж, ажил үүргийн давхардлыг арилгахыг аймгийн Засаг дарга, ХХААГ-ын дарга нарт зөвлөв.

1.2.3. Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд учруулсан зөрчил нь Баянхонгор аймагт 2016-2021 онд нийтийг хамарсан 2 удаагийн тохиолдлоор илэрсэн бөгөөд уг зөрчлийн аймгийн ЭМГ нь чиг үүргийн хүрээнд аймгийн МХГ-т мэдэгдсэний үндсэн дээр аймгийн МХГ нь зөрчлийн хянаж, зөрчлийн дагуу холбогдох арга хэмжээг авч ажилласан байна.

Тухайн гарсан тохиолдол тус бүрд нь Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 тоот тушаалаар баталсан “Хоол хүнсээр дамжих өвчний голомтод ажиллах заавар”, Сорьц, шинжлэгдэхүүн цуглуулах ба түүнтэй харьцах заавар”-ыг баримтлан зөрчлийн суурь шалтгааныг тодорхойлох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Дээрх зөрчлийн шалтгаан тодорхойлсны үндсэн дээр “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн тайлан мэдээний маягт”-ын дагуу тайлан мэдээг гаргаж Халдварт өвчин судлалын үндэсний төв болон аймгийн Засаг даргад мэдээллийг хүргүүлэн ажилласан байна.

1.2.4. Хүнсний аюулгүй байдал алдагдах нийтийг хамарсан хоолны хордлого халдварын тохиолдлын үед “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”, “ “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн тайлан мэдээний маягт” зэрэг 6 төрлийн журмыг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 тоот тушаалаар баталж зохицуулалтыг хангаж өгсөн байна.

Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 тоот тушаалаар баталсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”-д анхан шатны нэгж болон аймаг, нийслэлийн түвшинд авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээг үе шаттай тодорхойлж өгсөн байна.

Баянхонгор аймагт хүнсний аюулгүй байдал алдагдсан, нийтийг хамарсан хоолны хордлогын тохиолдол хоёр гарсан бөгөөд үүний нэг нь гаднаас зөөвөрлөгдөж ирсэн хүнснээс үүссэн бол нөгөө тохиолдол нь Шинэжинст сумын дотуур байранд гарсан хоол хүнсээр дамжсан байна.

Дээр зөөвөрлөгдөж ирсэн хүнснээс илэрсэн тохиолдол нь Хөвсгөл аймгаас иргэд өөрсдийн хэрэглээний зориулалтаар авчирсан савласан загаснаас үүссэн гэж мэргэжлийн байгууллага дүгнэсэн бол Шинэжинст сумын дотуур байранд гарсан хоол хүнсээр дамжсан халдварын дэгдэлт нь дараах шалтгаантай гэж дүгнэсэн байна. Үүнд:

1. Хоол үйлдвэрлэлийн хэсэгт ажилладаг 2 тогооч, 1 бэлтгэгч үйлчлэгч нийт 4 ажилтан эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамрагдаагүй.
2. Хоол үйлдвэрлэлийн гал тогоо байнга онгорхой, 19 цагаас хойш ямар ч хяналтгүй хүүхдүүд нэвтэрч түүхий ус хэрэглэдэг
3. Ундны усыг сумын төвийн эх үүсвэрийн худгаас усны машинаас зөөврөөр авдаг
4. Усны савыг угаах нарийн цэвэрлэгээний алчуур нэг
5. Хоол үйлдвэрлэлийн явцад бэлдсэн хоолыг дахин халааж хэрэглэдэг
6. Хүнсний бүтээгдэхүүн, хоолноос дээж авч тэмдэглэл хөтөлдөггүй, хөргөгчид байх дээжид он, сар тэмдэглэдэггүй
7. Хоолны аягыг сурагчдаар хуваарь гарган угаалгадаг, цэвэрлэгээний бодис хоолны зааланд ил байрлуулсан
8. Хүнсний ногоог урд өдөр нь бэлтгэж тасалгааны температурт байлгаж хэрэглэдэг
9. Хлорт нэгдлийг зааврын дагуу ашигладаггүй
10. Эрэгтэй сурагчдын байранд гар угаах угаалтуургүй
11. Хүнсний бүтээгдэхүүний хадгалалт хоол үйлдвэрлэлд хяналт тавьдаггүй

гэж дүгнэсэн байна

Аудитаар дээрх тохиолдын хувьд холбогдох баримт бичгийг мөрдсөн эсэхийг авч үзэхэд Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 тоот тушаалаар баталсан 6 төрлийн журмын дагуу үйлдэгдэх маягтуудыг аймгийн ЭМГ нь бүрэн үйлдсэн байна.

1.3. Баянхонгор аймгийн хэмжээний стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлээгүй, зарим гол нэрийн хүнсний бүтээгдэхүүн нь импортын бүрэн хамааралтай байна.

1.3.1. Монгол Улсын Их Хурлын 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.3⁵, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлд хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг тогтвортой байлгах, бүрдүүлэх, хүнсний нөөцийн талаар авч хэрэгжүүлэх талаар эрх зүйн зохицуулалттай байна.

Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу аймгийн Засаг дарга нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй байгаа ч хуулийн 6 дугаар зүйлийн 6.2⁶-т заасны дагуу Засгийн газар хүнсний нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг баталж өгөөгүй байгаа нь орон нутгийн түвшинд хуулийг хэрэгжүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлж нарийн зохицуулж өгөөгүй байна.

Иймд “Стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журам”-ыг батлан мөрдүүлэх зөвлөмжийг холбогдох эрх бүхий газарт хүргүүлэх саналыг ҮАГ-т уламжлав.

Харин Улсын онцгой комиссын 2020 оны 11 дүгээр тогтоолын хүрээнд ХХААХҮС хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, нийлүүлэлтийг тасалдуулахгүй байх чиглэлийг ирүүлсний дагуу аймгийн ХХААГ нь 2020 оны 03 сараас эхлэн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн хангамжийн судалгааг бүх сумд, аймгийн төвийн томоохон хүнсний худалдааны дэлгүүр, худалдааны төвүүд зэрэг нийт 236 хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдээс 7 хоногт 2 удаа авч ХХААХҮЯ болон аймгийн ЗДТГ-т хүргүүлж ажилласан байна.

⁵ стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлт, хэрэглээний онцлогтой уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлэх;

⁶ Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална.

Хүснэгт №2. Хүнсний нөөцийн судалгаа /тн/

Бүтээгдэхүүний нэр	2020.03 сар	2020.08 сар	2020.11 сар	2020.12 сар	2021.03 сар	2021.06 сар	2021.09 сар
Малын мах	248.5 ▲	272.8 ▲	381.2 ▲	454.6 ▼	395.6 ▼	214.9 ▼	37.2
Гурил	230.4 ▲	290.9 ▲	396.1 ▼	341.3 ▼	224.1 ▲	297.0 ▲	366.8
Гурилан бүтээгдэхүүн	19.0 ▲	31.7 ▲	70.1 ▲	77.9 ▼	67.0 ▲	106.3 ▼	74.7
Төрөл бүрийн будаа	50.0 ▲	75.9 ▲	169.5 ▼	168.9 ▼	109.4 ▲	120.3 ▲	183.9
Хуурай сүү	6.2 ▲	10.3 ▼	7.8 ▲	8.1 ▲	9.9 ▲	10.3 ▼	8.8
Өндөг	6.2 ▼	1.8 ▲	6.1 ▼	3.0 ▲	7.2 ▲	10.2 ▼	10.1
Ургамлын тос	22.5 ▼	20.6 ▼	13.5 ▲	603.3 ▼	11.8 ▲	19.2 ▲	20.5
Төмс	72.7 ▼	55.3 ▲	428.5 ▲	494.1 ▼	204.8 ▼	157.3 ▼	31.8
Хүнсний ногоо	14.2 ▲	14.4 ▲	381.3 ▲	424.5 ▼	231.3 ▼	196.1 ▼	15.9
Элсэн чихэр	36.7 ▲	45.6 ▼	41.4 ▲	42.3 ▼	30.5 ▲	33.5 ▲	48.0
Давс	29.4 ▲	31.4 ▼	30.6 ▲	37.1 ▼	21.2 ▲	22.2 ▲	26.5
Савласан ус	49.2 ▼	17.6 ▼	11.7 ▲	22.6 ▼	17.3 ▲	18.3 ▲	20.6
НИЙТ ДҮН	785.0 ▲	868.4 ▲	1,937.8 ▲	2,677.9 ▼	1,330.0 ▼	1,205.5 ▼	844.9

Эх сурвалж: ХХААГ-аас ХХААХҮЯ-д хүргүүлсэн судалгаа

Мөн Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5⁷ дахь заалтын хүрээнд 2020-2021 онуудад хүн амын хаврын улиралд шаардлагатай махны нөөцийг бүрдүүлэх, махны хомсдол, үнийн хөөргөдөл үүсгэхгүй, үнийг тогтворжуулах зорилгоор махыг иргэдэд хамгийн бага үнээр нийлүүлэх төсөл сонгон шалгаруулж орон нутгийн төсвөөс нийт 150.0 сая төгрөгийн санхүүжилт гарган “Баянхонгор констракшн” ХХК-тай гэрээ байгуулан хэрэгжүүлсэн байна. Тус ажлын хүрээнд 2020 онд 180 тн, 2021 онд 350 тн махыг зах зээлд гэрээнд заасан хөнгөлөлтэй үнээр худалдан борлуулсан байна.

Нөөцөд нийлүүлсэн махны хэмжээ /тн/



Нөөцөд нийлүүлсэн махны нэгжийн үнэ /төгрөгөөр/



Бусад гол нэрийн хүнсний нөөцийн тооцоолол, болон болзошгүй үед хэрэгжүүлэх нөөцийн асуудлын талаар шийдвэр гарган нөөц бүрдүүлж ажиллаагүй байна.

Цаашид Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу аймгийн хэмжээний стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

⁷ Нутаг дэвсгэрийнхээ хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээг тухайн шатны Засаг дарга авч хэрэгжүүлнэ.

1.3.2. Баянхонгор аймагт МХГ-ын Эрүүл ахуйн хими, нян судлалын лаборатори, аймгийн МЭГ-ын мал эмнэлгийн лабораториуд хүнсний шимт тэжээл, чанар, аюулгүй байдлыг шинжилж үйл ажиллагаа явуулж байна.

МХГ-ын лабораторийн үйл ажиллагаа нь “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандарт болон түүнд нийцүүлэн Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн ерөнхий захирлын 2020 оны А/35 дугаар тушаалаар баталсан “Үйл ажиллагааны бодлого арга зүйн заавар” болон түүнийг дагалдах 24 журмаар зохицуулагдаж байна.

Тус лаборатори нь МХЕГ-ын даргын 2013 оны “Лабораторийн жишиг бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай” 85 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Мэргэжлийн хяналтын газрын лабораторийг хими, хор судлалын лаборатори, нян судлалын лаборатори, ургамлын үр хорио цээрийн лаборатори гэсэн 3 лаборатори, 10 орон тоотой байхаар тогтоосон ч МХЕГ-аас бүтэц, орон тоог батлахдаа лабораторийг 5 орон тоотой байхаар төсвийг баталж өгсөн байна. Тус лаборатори нь Эрүүл ахуйн хими, нян судлалын 2 лабораторитой, лабораторийн эрхлэгч, химич, нян судлагч, лаборант гэсэн нийт 5 орон тоотойгоор ажиллаж байгаа ба дутуу 5 орон тооноос 1 орон тоо нь ургамлын үр, хорио цээрийн лаборатори байхгүйтэй холбоотой байгаа бол бусад дутуу орон тооны ажил үүргийг одоо байгаа алба хаагчид хавсран гүйцэтгэж байна.

Хүснэгт №3. Мэргэжлийн хяналтын лабораторийн орон тооны судалгаа

Албан тушаал	Байвал зохих	Одоо байгаа	Тайлбар
Лабораторийн эрхлэгч	1	1	-
Химийн шинжээч	2	1	Дутуу
Микробиологийн шинжээч	2	2	-
Ургамлын үр, хорио цээрийн шинжээч	1	-	Ургамал үр, хорио цээрийн лаборатори байхгүйтэй холбоотой.
Лаборант	2	1	Дутуу
Автоклавчин	1	-	Микробиологийн шинжээч нар хавсран гүйцэтгэж байна.
Шил угаагч	1	-	

Эх сурвалж: МХЕГ-ын даргын баталсан тушаал

Тухайлбал автоклавчин болон шил угаагчийн орон тоог нян судлагч нар хавсран гүйцэтгэж байгаа нь лабораторид ажиллах аюулгүй ажиллагааны горим, эрүүл ахуйн шаардлага хангахгүй байх эрсдэлийг үүсгэж болзошгүй байна.

Иймд орон нутаг дахь лабораторийн бүтэц, орон тоог МХЕГ-ын даргын тушаалаар баталсан лабораторийн жишиг бүтэц, орон тоонд нийцүүлж бий болгох зөвлөмжийг МХЕГ-т хүргүүлэх саналыг УАГ-т уламжлав.

Тус МХГ-ын лабораторийн ажиллах орчин нөхцөл болон тоног төхөөрөмжүүд нь “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандарт болон түүнд нийцүүлэн гаргасан “Үйл ажиллагааны бодлого арга зүйн заавар”, дагалдах журмуудтай нийцэж байна.

Тус лаборатори нь Стандарт хэмжил зүйн газрын 2019 оны А/302 дугаар тушаалаар химийн лабораторид 11 төрлийн бүтээгдэхүүнийг 174 үзүүлэлтээр, нян судлалын лабораторид 14 төрлийн бүтээгдэхүүнийг 194 үзүүлэлтээр 2022.12.27-ыг хүртэл сорилт гүйцэтгэх итгэмжлэлийг авсан байна.

Итгэмжлэлийн хүрээнд 2016-2020 онд нийт хүнсний бүтээгдэхүүний хими, хор, нян судлал, орчны хими, нян судлал, хөгц мөөгөнцрийн эрүүл ахуйн ахуйн нян судлалын шинжилгээг нийт 5796 дээжээс 15019 үзүүлэлтээр авснаас 23.6 хувь буюу 1369 дээж нь стандартын шаардлага хангаагүй эерэг үр дүнтэй гарсан байна.

Хүснэгт №4. Мэргэжлийн хяналтын лабораторийн хийсэн сорьц шинжилгээний судалгаа

Шинжилгээний төрөл		Хүнсний бүтээгдэхүүний хими, хор судлалын шинжилгээ	Хүнсний бүтээгдэхүүний нян судлалын шинжилгээ	Орчны химийн шинжилгээ	Орчны эрүүл ахуйн нян судлалын шинжилгээ	Хөгц мөөгөнцрийн эрүүл ахуйн нян судлалын шинжилгээ	НИЙТ ДҮН
2016 он	Дээжийн тоо	153	138	53	780	206	1330
	Үзүүлэлтийн тоо	670	322	471	1130	206	2799
	Эерэг дээж, үзүүлэлт	2	17		229	45	293
2017 он	Дээжийн тоо	153	181	58	553	28	973
	Үзүүлэлтийн тоо	809	384	338	1156	28	2715
	Эерэг дээж, үзүүлэлт	20	33		272	9	334
2018 он	Дээжийн тоо	97	156	62	478	109	902
	Үзүүлэлтийн тоо	305	486	113	921	109	1934
	Эерэг дээж, үзүүлэлт	27	18	23	188	28	284
2019 он	Дээжийн тоо	206	244	75	446	43	1014
	Үзүүлэлтийн тоо	765	880	306	991	43	2985
	Эерэг дээж, үзүүлэлт	31	36	10	102		179
2020 он	Дээжийн тоо	278	348	85	795	133	1639
	Үзүүлэлтийн тоо	888	1192	762	1683	133	4658
	Эерэг дээж, үзүүлэлт	31	26	52	133	37	279
НИЙТ	Дээжийн тоо	887	1067	333	3052	519	5858
	Үзүүлэлтийн тоо	3437	3264	1990	5881	519	15091
	Эерэг дээж, үзүүлэлт	111	130	85	924	119	1369
	Эзлэх хувь	12.5	12.2	25.5	30.3	22.9	23.4

Эх сурвалж: МХГ-ын лабораторийн жилийн эцсийн тоон тайлангууд

МХГ-аас 2019, 2020 онд “Нялх, балчир хүүхдийн хүнс, түүний сав баглаа боодол, шошгод урьдчилан сэргийлэх хяналт шалгалт”-аар Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан үзүүлэлтүүдийг шинжлэх талаар тус лабораторийн итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх шаардлагатай байгаа талаар шалгалтын танилцуулгад тусгасан байгаа нь лабораторийн хүчин чадал нь шаардлагатай сорьц, шинжилгээг хийх боломжгүй байгааг харуулж байна.

Иймд хэрэгцээ шаардлагад тулгуурлан лабораторийн хүчин чадал, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ ажиллах зөвлөмжийг аймгийн МХГ-т хүргүүлэв.

Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу орон нутаг дахь лаборатори нь хүнсний түүх эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын тандалт, судалгаа, дээжийн шинжилгээ хийн дүнгээ мэдээллийн нэгдсэн санд хүргүүлэх үүрэг хүлээсэн байна. Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лаборатори нь улсын хэмжээнд лабораторийн мэдээллийн удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, өгөгдлийн аюулгүй байдлыг хангах, цахим мэдээллийн санг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 08 дугаар сараас эхлэн gasi.shinjilgee.mn программыг нэвтрүүлж эхэлсэн ба тус программд дээжийг хүлээн авахаас эхлээд сорьц шинжилгээ хийх үр дүнг тодорхойлох хүртэл лабораторийн бүхий л үйл ажиллагааг бүртгэн мэдээллийн нэгдсэн сан үүсгэж байна.

Тус системд дээжээс сорьц шинжилгээ авч нотлох баримтыг хавсарган баталгаажуулж үр дүнг шууд хэвлэхээр тохируулж байгаа ба шинжилгээний хариуг өнгөт хэвлэгчээр хэвлэн дардас даран өгч байгаа нь шинжилгээний үр дүнг хэвлэн үнэт цаас эсхүл системээс дахин давтагдашгүй кодоор баталгаажуулж гаргахгүй байгаа нь шинжилгээний үр дүнг хуурамчаар үйлдэх эрсдэлээс бүрэн хамгаалагдаагүй, гарын үсэг зурж баталгаажихгүй байна.

Иймд шинжилгээний үр дүнг хэвлэн гаргах баталгаажуулах үйл ажиллагаанд үр дүнг хуурамчаар үйлдэх, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан шийдлийг цогцоор шийдэж сайжруулах зөвлөмжийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид хүргүүлэх саналыг ҮАГ-т уламжлав.

Баянхонгор аймгийн МЭГ-ын мал эмнэлгийн лаборатори нь анх 1959 онд анх оношилгооны кабинет нэртэйгээр байгуулагдсан одоогоор нян судлал, ийлдэс судлал, шимэгч судлал, ариун цэвэр гэсэн 4 лабораторид лабораторийн эрхлэгч-1 шинжлэгч эмч-4, лаборант-1 нийт 5 орон тоотойгоор үйл ажиллагаа явуулж байна.

Стандарт хэмжил зүйн газрын даргын 2019 оны А/317 тоот тушаалаар нян судлалын 15 төрлийн, ийлдэс судлалын 13 төрлийн, ариун цэврийн магадлан шинжилгээнд 3 төлийн бүтээгдэхүүнээс 28 төрлийн үзүүлэлтээр, шимэгч судлалыг 4 төрлийн үзүүлэлтээр сорилт гүйцэтгэх итгэмжлэлийг авсан 2016-2020 онд нийт 1605 иргэн, аж ахуйн нэгжийн хандалтаар 34759 дээжид сорьц шинжилгээ хийсэн байна.

Хүснэгт №5. Мал эмнэлгийн лабораторийн сорьц шинжилгээний судалгаа

Үзүүлэлт		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт
Ариун цэвэр	Хандалтын тоо	3	127	113	247	154	644
	Дээжийн тоо	4	4558	140	273	195	5170
Ийлдэс судлал	Хандалтын тоо	5	159	55	92	128	439

Үзүүлэлт		2016 он	2017 он	2018 он	2019 он	2020 он	Нийт
Нян судлал	Дээжийн тоо	94	7786	674	18709	310	27573
	Хандалтын тоо	4	64	93	62	49	272
	Дээжийн тоо	6	81	110	80	90	367
Шимэгч судлал	Хандалтын тоо	2	15	51	45	137	250
	Дээжийн тоо	2	21	152	46	1428	1649
НИЙТ	Хандалтын тоо	14	365	312	446	468	1605
	Дээжийн тоо	106	12446	1076	19108	2023	34759

Эх сурвалж: Мал эмнэлгийн лабораторийн жилийн эцсийн тоон тайлангууд

Аудитын илрүүлэлт:

Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2⁸, ХХААХҮС-ын 2020 оны А/303 дугаар тушаалаар баталсан “Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам”-ын 5.1.2⁹-т заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Тухайлбал “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандартад нийцүүлж гарын авлага, журам зааврыг баталж сүлжээ лабораториуддаа мөрдүүлээгүй, харин аймгийн МЭГ “Мал эмнэлгийн лабораторийн чанарын гарын авлага” болон түүнийг дагалдах журмуудыг боловсруулан баталж үйл ажиллагаандаа мөрдөж байна. Мөн Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторийн албан хаагчдад “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандарт байхгүй, стандартын сургалтад огт хамрагдаагүй байна.

Иймд Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори нь хууль, журмаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж орон нутаг дахь сүлжээ лабораториуддаа нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг хүргүүлэх саналыг УАГ-т уламжлав.

Мал эмнэлгийн лабораторийн барилга нь 1960 онд аж ахуйн аргаар барьж ашиглалтад орсон цахилгаан дулаан, цэвэр усны шугамд холбогдсон 12 өрөөтэй байна. Тус барилгын 11 өрөөнд лабораторийн тоног төхөөрөмж техник хэрэгслийг байршуулсан ба дээж авч сорьц шинжилгээ хийхдээ ажилтнууд тус барилгад орж ирж үйл ажиллагаа явуулж байна.

Стандарт хэмжил зүйн газрын дэргэдэх Итгэмжлэлийн үнэлгээний төвийн 2019 оны үнэлгээний тайланд "...ажиллах зай, талбайн хэмжээ хангалттай агааржуулалтын системтэй, лабораторийн ерөнхий урсгал зөв..." гэсэн дүгнэлт өгч 3 жилийн хугацаатай итгэмжлэл олгосон байна.

Аудитын илрүүлэлт:

Харин Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2015 оны 05-07-003/80 тоот дүгнэлтээр тус барилга нь ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадамжгүй гэсэн

⁸ Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15.2, 15.3-т заасан мал, амьтны эрүүл мэндийн салбарт хамаарах чиг үүргийг хэрэгжүүлэх;

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6 “энэ хуулийн 15.3-т заасан лабораториудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, мэргэжил дээшлүүлэх болон стандартын сургалт зохион байгуулах;”

⁹ Сүлжээ лабораториудад стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан стандарт, арга аргачлалыг нэвтрүүлэх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

дүгнэлт гаргасан, аудитын явцад барилгыг газар дээр нь очиж үзэхэд барилгын ашигладаггүй үүдний өрөөний дээвэр нь цөмөрч нурсан, “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандартын 6.3.1¹⁰ дэх шаардлагыг хангахгүй байна.

Энэ талаар Мал эмнэлгийн газрын дарга өгсөн тайлбартаа “.... Мал эмнэлгийн лабораторийн өрөөнүүдийн орчноос агаарын сорьц суулгалтын аргаар авч шинжлэхэд эрүүл ахуйн шаардлага хангаагүй 10 литр агаарт хөгц мөөгөнцөр илэрсэн нь эрүүл ахуйн шаардлагыг бүрэн хангахгүй, шинжилгээ хийх орчин, сорьцыг шинжилгээний хариу үнэн зөв гарахад нөлөөлөх зэрэг шаардлагуудыг хангахгүй дүгнэлттэй учраас эмч нарын ажиллах боломж муу байна. Мал эмнэлгийн лабораторийн барилгын зураг төсөв 2014 онд Барилгын хөгжлийн төвөөс батлуулж, мэргэжлийн байгууллагаас өгсөн техникийн нөхцөлийн дагуу зураг төсөв хийгдсэн. Мал эмнэлгийн ерөнхий газарт мал эмнэлгийн лабораторийн тааз нурж цаашид ашиглах боломжгүй тул шийдвэрлэж өгнө үү гэсэн албан бичгийг үе шаттайгаар удаа дараа илгээсэн боловч шийдэгдээгүй” гэжээ. Мал эмнэлгийн газрын 2020.05.04-ны өдрийн 184 тоот албан бичгээр Мал эмнэлгийн ерөнхий газарт барилга бариулах санал зураг төсвийн хамт хүргүүлсэн байна.

Иймд Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторийн орчин нөхцөлийг сайжруулах зөвлөмжийг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх саналыг УАГ-т уламжлав.



Зураг: Мал эмнэлгийн барилгын гадна болон дотор талын зураг



Зураг: Мал эмнэлгийн барилгын дээвэр нь нурсан, ашиглалтгүй өрөө

Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторид нийт 43 нэр төрлийн багаж, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл ашиглаж байгаа ба эдгээр тоног төхөөрөмжүүдийг 2019 онд итгэмжлэлд хамрагдсанаас хойш шалгалт тохируулга хийлгэсэн тухай

¹⁰ Лабораторийн байгууламж, ажлын байрны орчин нөхцөл нь лабораторийн үйл ажиллагаанд тохиромжтой бөгөөд үр дүнгийн үнэн бодит байдалд сөрөг нөлөө үзүүлэхээргүй байна.

тэмдэглэгээг “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17025:2018” стандартын 6.4.8¹¹-д заасны байршуулаагүй, 6.4.7¹²-д заасан шалгалт тохируулгын хөтөлбөр байхгүй нь шалгалт тохируулгын хүчинтэй хугацаандаа байгаа эсэхийг хянах боломжгүй байгаа нь Хэмжил зүйн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2.1¹³ дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд лабораторийн багаж, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслүүдийг мэргэжлийн байгууллагын шалгалт тохируулгад бүрэн хамруулж, цаашид хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллах албан шаардлагыг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэв.

1.3.3. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.2.¹⁴-т заасан зорилтыг хангахын тулд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Иргэдээ аймгийнхаа нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүн, талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах” зорилт дэвшүүлэн жилийн бүрийн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн ирсэн ч нийт хүнсний хэрэгцээний 15-20 хувийг хангаж байна.

Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод “Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, аялал жуулчлалыг хослуулан кластер-хонгор нутгийн ирээдүй” зорилт дэвшүүлж, 4 салбарыг хөгжүүлэх замаар мах, сүүний үйлдвэрлэлийн голлох бүс нутгуудын мал сүргийг үйлдвэрлэлийн чиглэлээр нь бүсчлэн хөгжүүлж мал аж ахуйн түүхий эд бүтээгдэхүүнийг бэлтгэх, боловсруулах, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйл ажиллагаанд орчин үеийн техник, технологи нэвтрүүлэх, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт 3 салбарыг хөгжүүлэх талаар тусгасан байна.

Хүснэгт №6. Аймгийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан хүнсний салбарыг дэмжих зорилт

Салбар	Аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлогод тусгасан салбар	Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
Хуурай сүүний үйлдвэр	2016-2025	
Махны үйлдвэр	2016-2025	2016-2020
Хүнсний ногооны үйлдвэрлэл	2016-2025	2016-2020
Сүүний үйлдвэрлэл	2016-2025	2016-2020

Эх сурвалж: Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн ЗД-ын мөрийн хөтөлбөр

Аудитын илрүүлэлт:

ЖДҮХС болон “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-иар дамжуулан 2017-2020 онд хүнсний чиглэлийн 48 төсөлд нийт 1430.6 сая төгрөгийн зээл олгосон байгаагаас үзэхэд дээрх

¹¹ Шалгалт тохируулга хийх шаардлагатай эсвэл хүчин төгөлдөр байх хугацааг нь тодорхойлсон бүх төхөөрөмжийн шалгалт тохируулгын төлөв байдал, хүчинтэй хугацааг нь хэрэглэгч хялбар тодорхойлох шошго, код эсвэл өөр таних тэмдэг тавина.

¹² Лаборатори нь шалгалт тохируулгын хүчинтэй байдалд итгэлтэй байх зорилгоор шаардлагатай тохиолдолд үзлэг, хяналт, тохируулга хийх шалгалт тохируулгын хөтөлбөртэй байна.

¹³ хэмжих хэрэгслийг загварын туршилт, шалгалт баталгаажуулалтад хугацаанд нь бүрэн хамруулж байгаа эсэхэд хяналт тавих;

¹⁴ Монгол хүний амьдралын зайлшгүй хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүний 70-аас доошгүй хувийг дотоодын үйлдвэрлэлээр тогтвортой хангах техник, эдийн засгийн арга хэмжээ авна.

аймгийн богино, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан үйлдвэрүүдийг дэмжих талаар бодлого хэрэгжүүлж улс, орон нутгийн төсвийн хөрөнгийг оновчтой хуваарилаагүй байна.

ЖДҮХС-аас 2019-2020 онд хүнсний чиглэлийн 14 төсөлд нийт 854.6 сая төгрөгийн зээл олгосон байгаагаас сүү, цагаан идээ боловсруулах 8 төсөлд 604.6 сая төгрөгийн зээл олгосон байгаа хэдий ч аймагын хэмжээний сүү, сүүн бүтээгдэхүүний хангамжийн хувь тус онуудад өмнөх оноос буурсан үзүүлэлттэй байна.

“Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-иар дамжуулан орон нутгийн төсвөөс 2017-2018 онд хүнсний чиглэлийн 34 төсөлд нийт 576.0 сая төгрөгийн зээл олгосон байгаа ба үүнээс нийтийн хоол, хоол үйлдвэрлэлийн чиглэлийн 13 төсөлд 161.0 сая, сүү, цагаан идээ боловсруулах 7 төсөлд 130.0 сая төгрөгийн зээл олгосон байгаа нь төслийн санхүүжилтийн дийлэнх хувийг эзэлж байна.

Хүснэгт №7. Улс, орон нутгийн төсвөөс олгосон хөнгөлөлттэй зээлийн судалгаа

Зээлийн зориулалт	Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац ХХК								ЖДҮХСан				НИЙТ	
	2017		2018		2019		2020		2019		2020			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Гурилан бүтээгдэхүүн		-		-	5	35.0		-	1	40.0		-	6	75.0
Жимс, жимсгэнэ үйлдвэрлэх		-		-		-		-		-	1	100.0	1	100.0
Мал аж ахуй		-		-	1	20.0	1	15.0		-		-	2	35.0
Тахианы аж ахуй									1	20.0			1	20.0
Ангилсан махны худалдаа		-		-		-	1	25.0		-		-	1	25.0
Нийтийн хоол, хоол үйлдвэрлэл	1	50.0	4	34.0	4	51.0	4	26.0	1	50.0		-	14	211.0
Сав баглаа боодлын үйлдвэр	1	70.0		-		-		-		-		-	1	70.0
Сүү, цагаан идээ боловсруулах	2	65.0		-	1	15.0	4	50.0	7	306.0	1	298.6	15	734.6
Хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлэх		-	1	6.0		-	3	19.0		-		-	4	25.0
Өвөл зуны хүлэмж, зоорь барих									2	20.0			2	40.0
Цагаан будаа тариалах	1	95.0		-		-				-		-	1	95.0
НИЙТ ДҮН	5	280.0	5	40.0	11	121.0	13	135.0	12	456.0	2	398.6	48	1,430.6

Эх сурвалж: ХХААГ-ын судалгаа, ТАБ-ын санхүүгийн тайлангийн аудитын судалгаа

Мөн сумдын Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2016-2020 онуудад хүнсний чиглэлийн 178 төсөлд 1147.6 сая төгрөгийн зээл олгосон байгаагаас сүү, цагаан идээ боловсруулах 80 төсөлд 425.8 сая, нийтийн хоол, хоол үйлдвэрлэлийн 50 төсөлд 338.5 сая, гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэх 27 төсөлд 239.3 сая төгрөг олгосон байгаа нь гол хувийн жинг эзэлж байна.

Хүснэгт №8. Сум хөгжүүлэх сангаас хүнсний салбарт олгосон зээлийн судалгаа

Зээлийн зориулалт	2016		2017		2018		2019		2020		НИЙТ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гурилан бүтээгдэхүүн	1	3.5	12	80.3	4	23.5	6	105.0	4	27.0	27	239.3
Жимс, жимсгэнэ үйлдвэрлэх	1	7.0	1	16.0	1	5.0		-	1	20.0	4	48.0
Мал аж ахуй	1	2.0	1	5.0		-	1	10.0		-	3	17.0
Мах махан бүтээгдэхүүн	2	9.0	3	14.0		-		-		-	5	23.0
Нийтийн хоол, хоол үйлдвэрлэл	7	53.5	12	86.0	10	60.5	16	99.5	5	39.0	50	338.5
Өвөл зуны хүлэмж, зоорь барих		-	1	8.0		-		-		-	1	8.0
Сав баглаа боодлын үйлдвэр	1	5.0		-		-		-		-	1	5.0
Сүү, цагаан идээ боловсруулах	9	53.0	19	85.5	5	58.0	23	100.3	24	129.0	80	425.8

Зээлийн зориулалт	2016		2017		2018		2019		2020		НИЙТ	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хүнсний ногооны ургацыг нэмэгдүүлэх		-	4	15.0		-		-	2	10.0	6	25.0
Цай, ус үйлдвэрлэл		-		-	1	18.0		-		-	1	18.0
Нийт	22	133.0	53	309.8	21	165.0	46	314.8	36	225.0	178	1,147.6

Эх сурвалж: ХХААГ-ын судалгаа

Харин 2021 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 12000.0 сая төгрөгийн өртөг бүхий хөдөө, аж ахуйн үйлдвэрлэлийн кластер байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа бөгөөд тус төслийн хүрээнд 1000 тн-ы багтаамж бүхий мах, ногооны зоорь, ингэний хуурай сүүний үйлдвэрийн ажил хийгдэж эхлээд байна.

Цаашид улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг импортын бүтээгдэхүүний зохистой харьцааг хангах дотоодын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан бүх салбаруудад тэгш хүртээмжтэй, оновчтой хуваарилж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.




Хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын хангамжийн талаарх судалгааг аймгийн ХХААГазар, болон Статистикийн хэлтсийн мэдээ, мэдээлэлд тулгуурлан гаргахад гол нэрийн 16 төрлийн бүтээгдэхүүнээс 9 нэр төрлийн бүтээгдэхүүнийг

аймагтаа үйлдвэрлэн иргэдийн хүнсний хэрэгцээнд нийлүүлж байгаа бол загас, шувууны мах, гурил, буурцагт ургамал, ургамлын тос, цөцгийн тос, сахар зэргийг бусад улс, аймаг, хотуудаас импортоор оруулж ирж хэрэглэж байна.

Дотооддоо үйлдвэрлэсэн хүнсний бүтээгдэхүүний хангамжийг бүтээгдэхүүн тус бүрээр авч үзвэл махны хэрэглээг орон нутгаасаа бүрэн хангаж байгаа бол, бусад бүтээгдэхүүнийг бүрэн хангаж чадахгүй байгаа ч нийт хүн амын хүнсний хэрэглээний 14.5-21.0 хувийг дотоодын үйлдвэрлэлээсээ хангаж байна.

Хүн амын нийт хүнсний хэрэглээнд Баянхонгор аймгийн дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь





1.3.4. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан төрийн хяналтыг МХГ нь Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хүнсний сүлжээний бүх үе шатны үйл ажиллагаа, орчны эрүүл ахуй, аюулгүй байдалд хийх хяналт шалгалтыг төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хүнсний тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹⁵ дэх хэсэгт заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлэх үүрэгтэй ба тус хяналтыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн журмыг Засгийн газрын 2014 оны 157 дугаар тогтоолоор баталсан байна.

Аудитын явцад Баянхонгор суманд үйл ажиллагаа явуулдаг хүнсний томоохон супермаркетууд, талх нарийн боовны үйлдвэр, мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрээс түүвэрлэн газар дээр нь очиж хүнсний сүлжээний өөрт хамаарах шатанд дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаатай танилцлаа.

Хүнсний үйл ажиллагаа эрхлэгч зарим байгууллагууд дотоод хяналтын журам, төлөвлөгөө байхгүй, дотоод хяналтыг төлөвлөгөө байгаа ч үлгэрчилсэн журмын дагуу өөрт хамаарах сүлжээний онцлогт хамааруулан батлаагүй журмын дагуу хяналт шалгалтыг хэрэгжүүлж байгаа ч үйл ажиллагааг бүрэн хамруулж иж бүрэн хийж чадахгүй дотоод хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх талаар мэдээл ойлголт хангалтгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2¹⁶ дахь хэсэгт заасны дагуу хүнсний үйл ажиллагаа эрхлэгч нь дотоод хяналтын журамтай эсэх мэдээллийг МХГ-т ирүүлэх үүрэгтэй байгаа ч аймгийн МХГ-т хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдийн дотоод журамтай эсэх талаар нэгдсэн судалгаа бүртгэл байхгүй байна.

¹⁵ Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд дотоод хяналтыг хэрэгжүүлж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ чанар, эрүүл ахуй, аюулгүй байдлыг бүрэн хариуцна.

¹⁶ хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, иргэний регистрийн дугаар, хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, дотоод хяналтын журам.

Иймд аймгийн хэмжээний хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдийг хүнсний сүлжээний өөрт хамаарах хэсэгт дотоод хяналтыг хэрэгжүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог бий болгох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, зөвлөн туслах хяналт шалгалтыг явуулан мэргэжил, арга зүйгээр хангах зөвлөмжийг аймгийн МХГ-т хүргүүлэв.

Баянхонгор аймгийн МХГ нь 2016-2020 онд хүнсний чанар, стандарт, ургамал хамгаалал, хорио цээр, мал эмнэлэг, мал үржлийн чиглэлээр төлөвлөгөөт 570, төлөвлөгөөт бус 13, гүйцэтгэлийн 520 хяналт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлсэн байна.

Хүснэгт №9. Мэргэжлийн хяналтын газраас хүнсний чиглэлээр хийсэн хяналт шалгалтын нэгдсэн судалгаа

№	Хяналт шалгалтын нэрс	Хугацаа, оноор				
		2016	2017	2018	2019	2020
A	Төлөвлөгөөт хяналт шалгалт	126	146	118	101	79
1	Хяналт шалгалт	83	97	68	68	58
2	Зөвлөн туслах үйлчилгээ	43	49	50	33	21
Б	Төлөвлөгөөт бус хяналт шалгалт	4	3	1	3	2
1	Хяналт шалгалт	4	3	1	3	2
2	Зөвлөн туслах үйлчилгээ	-	-	-	-	-
В	Гүйцэтгэлийн хяналт шалгалтын нэрс	108	126	112	97	77
1	Хяналт шалгалт	73	85	65	66	56
2	Зөвлөн туслах үйлчилгээ	35	41	47	31	21
НИЙТ ДҮН		238	275	231	201	158


Эх сурвалж: МХГ-ын программаас авсан судалгаанууд

Төлөвлөгөөт хяналт шалгалтаар хамрагдвал зохих объектуудын 8.0-12.5 хувийг хамруулан шалгасан байгаа ба шалгалтаар илрүүлсэн зөрчлийн 8.0-33.8 хувийг арилгуулсан байна.




Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 2016-2020 онд нийт 13 объектод хяналт шалгалт хийж нийт 211 зөрчил илрүүлсэн ч үүнээс 2016 онд хийсэн хяналт шалгалтын 15 зөрчлийг барагдуулсан бусад зөрчлийг барагдуулаагүй байна.

Хяналт шалгалтад хамруулсан объект /тоо/



Хяналт шалгалтар илрүүлсэн зөрчлийн барагдуулалт /хувиар/




Гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2016-2020 онд нийт 520 объектод хяналт шалгалт хийж нийт 4913 зөрчил илрүүлснээс 3676 зөрчил буюу 74.8 хувийг нь барагдуулсан байна.

Хяналт шалгалтад хамруулсан объект /тоо/




Хяналт шалгалтар илрүүлсэн зөрчлийн барагдуулалт /хувиар/




Баянхонгор аймгийн МХГ нь 2016-2020 онд нийт 1103 объектод төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт хийж 16348 зөрчил илрүүлсэн ч үүнээс 6627 зөрчлийг арилгуулж 60.0 хувь буюу 9721 зөрчлийг арилгуулаагүй байна.

Нийт хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлийн тоо



Хяналт шалгалтар илрүүлсэн зөрчлийн барагдуулалт /хувиар/



Иймд хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч, хяналт шалгалтын үр нөлөө, үр дүнг гаргах зөвлөмжийг аймгийн Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлэв.

1.3.5. Баянхонгор аймгийн хэмжээнд хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт, мэдээллийн сан байхгүйгээс орон нутгийн хэмжээнд хүнсний нөөц, хэрэгцээ, хангамжийн хувь хэмжээг тооцох боломжгүй байна. Харин малын гаралтай болон ургамлын гаралтай бүтээгдэхүүнийг гарал үүслийг нэгтгэсэн мэдээллийн санг цахим хэлбэрээр үүсгэж хяналт тавих ажлыг 2019 оноос эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлж эхлээд байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системээр орон нутгаас Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2¹⁷ дахь хэсэгт заасан мал эмнэлгийн гэрчилгээнд заасан гарал үүслийг үндэслэн тус хуулийн 27.5¹⁸ дахь хэсэгт заасан мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний QR код бүхий гэрчилгээг олгож нийтийн хэрэгцээнд гарал үүсэл тодорхой эрүүл, аюулгүй мах, махан бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар тус ажлыг зохион байгуулахыг аймаг, нийслэлийн мал эмнэлгийн газарт үүрэг болгосны дагуу Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн газрын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалаар “Мал эмнэлэг, ариун цэврийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээ нэвтрүүлэх ажлын удирдамж” ажлын хэсгийг томилсон байна.

Мал эмнэлгийн нэгдсэн системийг Баянхонгор аймагт 2019 оны 06 дугаар сараас эхлэн нэвтрүүлсэн ба түүнээс хойш нийт 35758 мал эмнэлгийн гэрчилгээг тус цахим системээр олгосноос хүнсний хэрэглээний зориулалтаар 476330 толгой мал, 993.7 тн малын мах, 23.4 тн сүү, цагаан идээ, амьтад, үйлдвэрлэл, худалдааны зориулалтаар 32140 толгой мал, 4181.3 тн малын мах, 59.4 тн сүү, цагаанд идээнд гарал үүслийн гэрчилгээ олгосон байна.

¹⁷ Энэ хуулийн 27.1-д заасан үйл ажиллагааны үр дүн, 7.4.2-т заасан баримт нотолгоог үндэслэн үзлэг хийсэн албан тушаалтан түүхий эд, бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгоно.

¹⁸ Магадлан шинжилгээгээр эрүүл ахуй, ариун цэврийн шаардлага хангасан нь тогтоогдвол мал, амьтны гаралтай хүнсний түүхий эдэд шинжилгээ хийсэн лаборатори магадлан шинжилгээний гэрчилгээ олгоно.

Хүснэгт №10. Малын гаралтай бүтээгдэхүүнд олгосон гарал үүслийн судалгаа

Үзүүлэлт			Хүнсэнд	Үржлийн зориулалтаар	Үзэсгэлэн худалдаан зориулалтаар	Алдуул мал	Үйдвэрлэл худалдааны зориулалтаар	Отор нүүдлийн зориулалтаар	НИЙТ ДҮН	
Олгосон гэрчилгээ			10,185.0	1,064.0	247.0	2.0	20,874.0	3,389.0	35,761.0	
Гарал үүслийн гэрчилгээ олгосон хүнсний бүтээгдэхүүн	Тоо, толгойгоор	Тэмээ	1,964.0		8.0			6,742.0	8,714.0	
		Адуу	21,774.0	2,699.0	1,357.0	11.0	1.0	22,222.0	48,064.0	
		Үхэр	18,630.0	1,127.0	207.0		14.0	10,498.0	30,476.0	
		Хонь	123,037.0	13,212.0	1,660.0		284.0	110,373.0	248,566.0	
		Ямаа	300,740.0	24,414.0	6,184.0		1,304.0	279,984.0	612,626.0	
		Гахай		43.0				5.0	48.0	
		Тахиа		2,566.0					2,566.0	
	Бүтээгдэхүүний жингээр	Мах /тн/	Тэмээ	45.1	-	-	-	170.9	-	216.0
			Адуун	-	-	-	-	302.2	-	302.2
			Үхэр	380.5	-	-	-	1,132.8	-	1,513.3
			Хонь	20.5	-	-	-	1,009.2	-	1,029.8
			Ямаа	547.6	-	-	-	1,566.2	-	2,113.8
		Айраг /тн/		1.3	-	-	-	7.2	-	8.5
		Сүү /тн/		14.9	-	-	-	14.0	-	28.9
		Бусад цагаан идээ /тн/		7.2	-	-	-	38.1	-	45.3

Эх сурвалж: Мал эмнэлгийн улсын байцаагчийн тайлан

Мал эмнэлгийн нэгдсэн системд бүртгэлтэй гарал үүслийн гэрчилгээнд үндэслэн худалдааны төв, зах, хүнсний дэлгүүрүүдээр худалдан борлуулагдаж буй маханд QR код бүхий Мал эмнэлэг ариун цэврийн магадлан шинжилгээний цахим гэрчилгээг олгох ажлыг 2021 оноос эхлэн нэвтрүүлээд байгаа ба одоогоор аймгийн төвийн Дунд зах худалдааны төвийн В-1 давхрын махны зааланд туршилтын журмаар нэвтрүүлэн ажиллаж байна. Нэвтрүүлж эхэлснээс хойш 2021 оны 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэлх хугацаанд давхардсан тоогоор нийт 110-н иргэний 8,8тн малын маханд QR код бүхий магадлан шинжилгээний цахим гэрчилгээг олгоод байна.

Төлөв: Баталсан
 МШГ дугаар: МШГ908805
 Энэ гэрчилгээ нь Meg908739 гэрчилгээнээс үүссэн.
 Үүсгэсэн эмч: Г.Жүгдэрмаа
 Үүсгэсэн огноо: 2021-11-02 10:48:39
 Зориулалт: Хүнсэнд
 Хүчинтэй хугацаа:
 2021-11-02 – 2021-11-03
 Дүнгийн хуудас: –
 Хаанаас:
 Нэр: Азаяа
 Хаяг: Баянхонгор, Баянхонгор, 1-р баг, Номгон
 Хаашаа:
 Нэр: Агт бүрд ХХК
 Хаяг: Баянхонгор, Баянхонгор, 1-р баг, Номгон
 Бэлчээрийн төлөв байдал:
 тодорхойгүй
 Хариуцагчийн нэр: Азаяа
 Хариуцагчийн утас: 88408684
 Лангууны дугаар: Дунд захын 8-р лангуу
 Тээвэр:
 Тайлбар:
 Хийгдсэн шинжилгээ:
 Шинэлэг байдал, pH, Мэдрэхүйн үзлэг
 Бүтээгдэхүүний мэдээлэл
 Мах
 Мал: Хонь



Харин малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн худалдаалж буй бусад хүнсний дэлгүүр худалдааны төвүүд нь малын гаралтай бүтээгдэхүүнийг шинжлэх

зориулалтын лабораторигүй байгаа нь Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2¹⁹ дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Мал эмнэлгийн газрын явуулын лабораторийг малын гаралтай бүтээгдэхүүн борлуулж буй зах, худалдааны төвүүдэд ажиллуулж, хүнсний бүтээгдэхүүнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гарал үүслийн гэрчилгээг дэвшилтэт технологиор баталгаажуулж буй ажлын цар хүрээг нэмэгдүүлж, ард иргэдэд тус үйл ажиллагааг таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах зөвлөмжийг аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэв.

Мөн сургууль, цэцэрлэгт мал гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэхдээ мал итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу болон QR код бүхий гэрчилгээг дээж тус бүрээр авахгүй, их хэмжээгээр нэг удаа авч хэсэгчлэн нийлүүлэлт бүрд ашиглаж байгаа нь тус шинжилгээний бичгийг ашиглан өөр гарал үүсэл бүхий бүтээгдэхүүн нийлүүлэгдэх эрсдэлтэй байна.

Хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдээс зах зээлд бэлтгэн нийлүүлж буй ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, таримал ургамлын үр, суулгацын гарал үүслийг тогтоох, хүнсний сүлжээний бүх үе шатанд чанар аюулгүй байдлыг хангах зорилгоор бүртгэл, хяналтын тогтолцоо, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх эрх зүйн зохицуулалтыг Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/105 дугаар тушаалаар “Ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн журам”-ыг баталж журмын хүрээнд 2021 оныг хүртэл цаасан хэлбэрээр бүртгэлийг хөтөлж, гарал үүслийн тодорхойлолтыг олгож байсан байна. Харин 2021 оноос эхлэн “Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын систем”-ийг нэвтрүүлж, хүнсний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчдээс зах зээлд бэлтгэн нийлүүлж буй ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, таримал ургамлын үр, суулгацын гарал үүслийг тогтоох бүртгэх үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн ба Баянхонгор аймгийн хувьд тус системд 51 иргэн, аж ахуйн нэгжийн 519.3 га талбайн мэдээллийг бүртгэсэн байгаа нь нийт тариалангийн талбайн 40 хувь, газар тариалан эрхлэгчдийн 16.0 хувийг хамруулсан байна. Харин иргэн, аж ахуйн нэгжүүд тариалсан талбайн хэмжээ, тарьсан бүтээгдэхүүний нэр төрөл, ургац хураалтын мэдээллийг бүртгэж системийг ашиглаагүй байна.

Иймд “Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын систем”-ийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулах, системд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

¹⁹ хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шатанд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийхээ аюулгүй байдлыг хариуцах

1.3.6. Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 91²⁰ дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор аймгийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд “Органик хүнс” төсөл боловсруулан хэрэгжүүлэх зорилт дэвшүүлэн “Органик хүнс” төслийг боловсруулах ажлыг томилж хөтөлбөрийн төслийг боловсруулан танилцуулахад бэлэн болсон гэж биелэлтийг тайлагнасан байх боловч одоо болтол тус хөтөлбөрийг баталж хэрэгжүүлээгүй байна.

Мөн аймгийн ЭМГ-т хүн амын хоол тэжээлийн талаар судалгаа байхгүй, бодлого тодорхойлох төрийн байгууллага, албан тушаалтныг үнэн зөв бодит мэдээллээр хангах нэгдсэн мэдээллийн сан байхгүй байгаа нь аймгийн хэмжээнд Хүнсний тухай хуулиар тодорхойлсон шим тэжээллэг болон органик хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх үндэс суурь тавигдаагүй байна.

Харин жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас шим тэжээллэг бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрийг нэмэгдүүлэх зорилгоор “Эхлэл” тахианы аж ахуйн төслийг бодлогоор дэмжсэнээр 2018 оноос эхлэн жилд дунджаар 850.000 ширхэг өндгийг аймгийнхаа зах зээлд нийлүүлж байгаа нь аймгийн нийт өндөгний хэрэглээний 27-33 хувийг хангаж байна.

Иймд хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар судалгаа, мэдээллийн сан үүсгэж аймгийн удирдлагыг тогтмол мэдээллээр хангаж байх зөвлөмжийг аймгийн ЭМГ-т хүргүүлэв.

1.3.7. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.4.2.6²¹, 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.10²², 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Ногоон хөгжлийн бодлого”-ын 3.1.6²³-дахь зорилтуудад сав баглаа боодлын талаар төрөөс авч хэрэгжүүлэх бодлогыг тодорхойлсон бөгөөд Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолоор “Сав, баглаа боодол” үндэсний хөтөлбөрийг баталсан байна.

²⁰ Иргэдээ аймгийнхаа нутагт дэвсгэрт үйлдвэрлэсэн төмс, хүнсний ногоо, мах махан бүтээгдэхүүн, талх нарийн боов, жимс жимсгэнээр хангах “Органик хүнс” төсөл хэрэгжүүлнэ.

²¹ Мал эмнэлгийн тогтолцоог шинэчилж, малын халдварт өвчинтэй тэмцэх чадавхыг дээшлүүлж, халдвар, хамгаалал, био аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгоно. Монгол малын удмын сан, үр тарианы нутагшмал сортыг хамгаална. Байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй хүнсний сав, баглаа боодол, бордоо, ургамал хамгааллын бодис ашиглах хяналтыг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ.


²² хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх үе шатанд хэрэглэх, дэвшилтэт технологийг нутагшуулах, үйлдвэрлэлийг хөгжүүлэхийг дэмжинэ.

²³ Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээг боловсронгуй болгож, байгальд халгүйгээр хадгалах, савлах технологийг дэмжинэ.

Тус тогтоолын дагуу ХХААГ-ын даргын 2017 оны 12 дугаар тушаалаар “Сав баглаа боодол үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөө”-г баталсан ба төлөвлөгөөнд нийт 12 зорилтыг хэрэгжүүлэхээр төлөвлөн хэрэгжилтийг тайлагнаж иржээ.

Тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хүнсний сав, баглаа боодолд тавих эрүүл ахуйн шаардлага өндөрсөж, бараа бүтээгдэхүүний сав, баглаа боодолтой харьцах хэрэглэгчдийн хандлага, сонголт өөрчлөгдөж, мэдлэг нэмэгдсэн, зориулалтын сав, баглаа боодлын хэрэглээ буурч, сав баглаа боодол хаяг шошгын дотоодын үйлдвэрлэл, хангамжийн хэмжээ нэмэгдсэнээр хөтөлбөрийн үр дүн гарахаар байна.

Гэвч Баянхонгор аймгийн хэмжээнд тус шалгуур үзүүлэлтүүдийг суурь түвшин, хүрэх түвшнийг тооцож төлөвлөөгүй, тухайн шалгуур үзүүлэлтүүдийн гүйцэтгэлийн талаар тоон мэдээлэл хангалтгүйгээс аудитаар ахуйн хэрэглээнд байгаа хүнсний зориулалтын бус хуванцар сав, баглаа боодлын хэрэглээ хэрхэн буурсныг тооцох боломжгүй байгаа ч бодит байдал дээр ард иргэдийн дунд зориулалтын бус хуванцар сав, баглаа боодлын хэрэглээ байсаар байна.



Баянхонгор аймгийн МХГ нь Засгийн газрын 2015 “Хүнсний зориулалтын бус хуванцар савны талаар авах зарим арга хэмжээний тухай” 496 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс 2017 онд хүнсний худалдаа, үйлдвэр эрхлэгч 69 иргэн, аж ахуйн нэгжийн хуванцар савыг шинжилгээнд хамруулж чанар аюулгүй байдлыг шалгахад эерэг дүнтэй сорьц илрээгүй бөгөөд шинжилгээний бичиггүй сав баглаа боодлыг ашиглаж байсан зөрчилд зөвлөмж өгч хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна.

Мөн дээрх тогтоолын хүрээнд 2018 онд Баянхонгор сумын 13 хүнсний бөөний худалдааны төв, хүнсний 8 үйлдвэрийг хамруулан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний шошгололтын байдалд тандалт судалгааг МХГ-аас хийж үйлдвэрлэсэн он, сар, өдөр бичигдээгүй, хадгалах болон хэрэглэх хугацаа дууссан, тэжээллэг чанар, орц найрлага бичигдээгүй, гаж нөлөө, хориглох заалт бичигдээгүй зэргээр нийт 254 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгах талаар мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөн ажилласан байна.

Засгийн газрын 2018 оны 189 дүгээр тогтоолоор бүх төрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг 2019 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хориглох шийдвэр гарсны дагуу Баянхонгор аймгийн ХХААГазар, Эрүүл мэндийн газруудаас “Цүнхэндээ даавуун тортой”, “Хүнсний бус зориулалтын хуванцар савгүй аймаг болох” гэх мэт уриалга, нөлөөллийн ажлуудыг хийсэн байна.

Аудитын илрүүлэлт:

Баянхонгор аймгийн ХХААГ, МХГ-т тухайн нийлэг хальсан уутны зузааныг хэмжих багаж тоног төхөөрөмж байхгүйгээс зөвхөн уутан дээрх тэмдэглэгээг харах байдлаар хяналт тавьж байна.

Мэргэжлийн хяналтын газар нь 2019, 2020 онуудад нялх балчир хүүхдийн хүнсний найрлага, сав, баглаа боодол, шошгод тавих ерөнхий шаардлагыг хангуулах зорилгоор нийт 44 хүнсний худалдааны газар, 10 аж ахуйн нэгж, 32 иргэнийг хамруулан шалгаж гарсан зөрчлийг арилгуулах албан шаардлага өгч, шалгалтад хамрагдсан худалдааны төв, аж ахуйн нэгжийн нийт 63 ажилчдад Нялх балчир хүүхдийн хүнсний тухай хууль, хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгод тавих шаардлага, гарал үүсэл, баталгаажуулалтын бичиг зэрэг сэдвээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан байна.

Гэсэн хэдий ч аймгийн хэмжээнд иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодлын хэрэглээний талаар нэгдсэн дүн судалгаа, аль ч төрийн байгууллагад байхгүй, төр засгаас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн хэрхэн гарсан талаар тооцох боломжгүй байна.

Иймд хүнсний зориулалтын сав, баглаа боодлын хэрэглээ, дотоодын үйлдвэрлэл, хангамжийн талаар нэгдсэн мэдээллийн сан үүсгэж дүн шинжилгээ хийн түүнд чиглэсэн бодлого боловсруулж Засгийн газрын 2016 оны 287 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ХХААГ-т хүргүүлэв.

1.3.8. 2015 оны 104 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого”-ын 4.1.10²⁴ дахь зорилтыг хангах, хоол тэжээлийн талаарх хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангаж, хоол тэжээлээс хамааралтай өвчин, эмгэгийг бууруулах зорилгоор Засгийн газрын 2015 оны 447 дугаар тогтоолоор “Хүн амын хоол тэжээл” үндэсний хөтөлбөрийг баталсан байна.

²⁴ хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх.

Баянхонгор аймгийн “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр”-ийг 2017-2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2017 оны А/823 дугаар захирамжаар баталж 2017 оноос хэрэгжүүлж эхэлсэн байна.

Тус хөтөлбөрийн “хүн амын дунд хоол тэжээлийн талаарх мэдээлэл, сургалт, сурталчилгааг өргөжүүлэх” зорилтын хүрээнд нийт 6 арга, хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж жил бүр хэрэгжилтийг тайлагнаж байна.

Тухайлбал: хүнсний бүтээгдэхүүний сонголт, хадгалалт, зөв зохистой хооллох, хоол хүнсээр дамжих өвчлөлөөс сэргийлэх, давсны хор хөнөөл хэрэглээг бууруулах зэрэг сэдвүүдээр иргэд, олон нийт, аж ахуйн байгууллагуудад сургалт зохион байгуулах орон нутгийн телевизээр богино хэмжээний сурталчилгааны нэвтрүүлэг явуулах, олон нийтийн цахим сүлжээгээр түгээх зэргээр хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх нөлөөллийн арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг нийт 26 шалгуур

үзүүлэлтээр үнэлэхээр тодорхойлсон ба Баянхонгор аймгийн 2020 оны жилийн эцсийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнахдаа 10 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг гаргаагүй, 16 үзүүлэлтийн хүрсэн түвшнийг тооцож гаргасан байгаагаас 5 шалгуур үзүүлэлт 2020

№	Үзүүлэлт	2020 оны зорилтот түвшин	2020 оны гүйцэтгэл
1	5 хүртлэх насны хүүхдийн бүх хүүхдийн дунд туранхай хүүхдийн эзлэх хувь	≤1.0	1.5
2	Өрхийн иоджуулсан давсны хэрэглээний түвшин	80	64
3	Олон найрлагат бичил тэжээлийн бэлдмэлийн түгээлтэд хамрагдсан 6-23 сартай хүүхдийн хувь	≥90	77.7
4	15-64 насны хүн амын илүүдэл жингийн тархалтын хувь	≤53.0	64
5	15-64 насны хүн амын таргалалтын тархалтын хувь	≤18.0	25

оны зорилтод түвшиндээ хүрээгүй байгаа нь “Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үр дүн гараагүй байгааг харуулж байна.

Хүснэгт №11. Шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг гаргаагүй зорилтууд

№	Үзүүлэлт	2020 оны зорилтот түвшин	2020 оны гүйцэтгэл
1	5 хүртэлх насны хүүхдийн дунд Д аминдэмийн дуталтай хүүхдийн эзлэх хувь	25	-
2	5 хүртэлх насны хүүхдийн дунд А аминдэмийн дуталтай хүүхдийн эзлэх хувь	25	-
3	5 хүртэлх насны хүүхдийн дунд цус багадалттай хүүхдийн эзлэх хувь	25	-
4	5 хүртэлх насны хүүхдийн дунд төмрийн дуталтай хүүхдийн эзлэх хувь	18	-
5	Төрөх насны эмэгтэйчүүдийн дунд цус багадалттай эмэгтэйчүүдийн эзлэх хувь	12	-
6	Хүн амын дунд жимс, хүнсний ногоог 5 нэгжээс бага хэмжээгээр хэрэглэдэг хүн амын эзлэх хувь	90	-
7	Жимс, жимсгэнийн жилийн хэрэглээ (кг)	30	-
8	Хүнсний ногооны жилийн хэрэглээ (кг)	40	-
9	Чихэр, сахрын зүйлийн жилийн хэрэглээ (кг)	12.8	-
10	Илчлэгийн хэрэглээ (ккал)	2300	-

Эх сурвалж: Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт

Мөн аудитын явцад
аймгийн Эрүүл мэндийн
газраас хоол хүнснээс
хамааралтай өвчлөлийн
статистик мэдээг хөтөлбөр
хэрэгжиж эхэлсэн
хугацаанаас хойш
гаргуулахад нийт 9 төрлийн
өвчлөлөөс 8 төрлийн өвчлөл өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 12. Хоол хүнснээс хамааралтай өвчлөлийн статистик мэдээлэл

Бүтээгдэхүүний нэр	2017 он	2018 он	2019 он	2020 он
Хүнсний гаралтай бактерийн хордлого	7.0 ▼	- ▲	1.0 ▲	43.0
Ходоодны өмөн	2.0 ▲	4.0 ▲	20.0 ▲	27.0
Иод хомсдолтой хамааралтай бамбайн өвчнүүд	9.0 ▼	8.0 ▼	5.0 ▲	6.0
Аминдэм Д-ийн хомсдол	38.0 ▲	136.0 ▼	111.0 ▼	80.0
Халдварт бус суулгалт өвчин	1,350.0 ▲	2,192.0 ▲	2,314.0 ▼	2,297.0
Хоол шингээх эрхтний бусад өвчин	18.0 ▼	6.0 ▲	34.0 ▲	63.0
Мухар олгойн өвчин	191.0 ▼	73.0 ▲	166.0 ▲	193.0
Тарга	29.0 ▲	31.0 ▼	28.0 ▲	29.0
Халдварын гаралтай суулгалт өвчин	10.0 ▼	13.0 ▼	10.0 ▲	15.0

Эх сурвалж: ЭМГ-ын статистик мэдээлэл

Иймд хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг тухай бүр шалгуур үзүүлэлтийн дагуу тооцож хэрэгжилтийг бодитоор үнэлж байх зөвлөмжийг аймгийн ЭМГ-т хүргүүлэв.

БҮЛЭГ 2. ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАД ТАВИХ ХЯНАЛТЫГ ОНОВЧТОЙ ХЭРЭГЖҮҮЛЭЭГҮЙГЭЭС ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ҮР АШИГ БОДИТОЙ ГАРАХГҮЙ БАЙНА.

2.1. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө, хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй байна.

2.1.1. Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор тухайн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааг шаардлагатай төсөв санхүүгийн хамт төлөвлөн аймгийн ИТХ-н хурлаар хэлэлцэн баталж байна.

Аймгийн хэмжээнд 2016-2020 онд хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, аюулгүй байдлыг хангах чиглэлээр давхардсан тоогоор 29 зорилтыг үндсэн чиглэлд тусгаж хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба үүнээс 8 зорилтод шаардагдах нийт 320.0 сая төгрөгийг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс санхүүжүүлэхээр баталж бусад зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдахад санхүүжилтийн баталгаат эх үүсвэр, хөрөнгийн тооцоо судалгааг гаргаж батлуулаагүй байгаа нь Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1²⁵ дахь хэсэгт заасантай нийцэхгүй байна.

Цаашид аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахдаа шинэчлэн найруулагдсан Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

2.1.2. Баянхонгор аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөхдөө хэрэгцээ шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй байна.

²⁵ Аймаг, нийслэл, сум, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дэд хөтөлбөрт үндэслэн тухайн жилд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ, хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт, хариуцах байгууллага, төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэрийг тодорхойлсон байна.

2.2. Төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг оновчтой хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгийн үр ашиг бодитой гарахгүй байна.

2.2.1. Баянхонгор аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, үндэсний хөтөлбөрүүдэд заасан хүн амын хүнсний чанар, хүртээмж, аюулгүй байдлыг хангах чиглэлээр тусгагдсан зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор улс, орон нутгийн төсөв, хөнгөлөлттэй зээл, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр нийт 2251.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

Хүснэгт №13. Үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан хөрөнгийн судалгаа /сая.төг/

Хөтөлбөрийн нэр	Улсын төсөв	ОНТөсөв	ОНХС	СХСан	ЖДҮД зээл	Төсөл хөтөлбөр	Нийт дүн
Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр	207.0	50.0	-	18.0	-	43.2	318.2
Монгол мал	67.1	20.0	-	-	-	-	87.1
Сав баглаа боодол үндэсний хөтөлбөр	-	-	-	-	70.0	-	70.0
Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр	-	-	80.0	-	328.0	80.0	488.0
Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-3 үндэсний хөтөлбөр	-	-	-	-	-	11.0	11.0
Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөр	25.7	7.8	-	-	-	131.7	165.2
Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр	46.6	443.4	36.4	96.4	20.0	90.0	732.8
Эрүүл хүнс, Эрүүл Монгол хүн үндэсний хөтөлбөр	-	75.0	-	-	303.8	-	378.8
НИЙТ ДҮН	346.4	596.2	116.4	114.4	721.8	355.9	2,251.1

Эх сурвалж: Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилт

Баянхонгор аймагт төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтыг нэмэгдүүлэх, өрхийн амь зорилгоор орон нутгийн төсвөөс 160.0 сая төгрөг зарцуулж нийт 90 өрхийг хамруулан хэрэгжүүлсэн байна.

Тус ажлын хүрээнд нийт 2017-2019 онд “Жимс жимсгэнийн тариаланг дэмжих” төслийн хүрээнд нийт 30 айлд мод тарих зорилгоор 6 дугаар багийн нутаг дэвсгэрт гудамжны ард газар олгож бүлэг хэлбэрээр зохион байгуулж хашаажуулан мод тарьж хашаа барьсан, мөн 2020 онд 48.0 сая төгрөгөөр тариаланчдыг цахилгаан эх үүсвэрээр хангах, 12.0 сая төгрөгөөр гүний худаг гаргах ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Тус ажлын хэрэгжилтийг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг 2017-2018 онд хэрэгжүүлсэн ажлын үр дүн, 2020 онд олгосон ажлын хэрэгжилтийг 2021 онд 06 дугаар сард газар дээр нь очиж шалгасан ба 2017-2018 төслийг хэрэгжүүлсэн 60 өрхөөс 3 өрх нь төслийг зориулалтын дагуу хэрэгжүүлээгүй байгаа тул газар эзэмших эрхийг түдгэлзүүлэх, 2020 онд олгосон санхүүжилтийн хүрээнд тариалангийн талбайн цахилгааны эх үүсвэр, гүний худгийн асуудлыг шийдвэрлэсэн боловч 2020 онд тариалалт хийгдээгүй, 2021 онд тариалалтын явц хангалтгүй байгаа тул ажлыг эрчимжүүлэх шаардлагатай байгаа талаар тайлагнасан байна.

Мөн 2021 онд “Орон нутгийн төсвийн 2019-2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар 2020 онд

хэрэгжүүлсэн 30 өрхийн төслийн хэрэгжилтийг газар дээр очиж үзэхэд зарим айлын хашаандаа модоо ургуулаагүй орхигдсон байгаагаас үзэхэд төслийн хөрөнгө үр ашиг бүрэн гараагүй байсан тул дээрх хөрөнгийн үр ашгийг сайжруулах, мод бут сөөгийг нөхөн тарьж ургуулан төслийн үр ашгийг гаргах албан шаардлагыг “Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпорац” ХХК-д хүргүүлсэн байна.

2.2.2. Хүн амын хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналтыг хангалттай түвшинд хэрэгжүүлээгүйгээс төрийн бодлого шийдвэрийн биелэлтийг үнэн зөв, бодитой тайлагнаж чадахгүй байна.

Тухайлбал: “Сав баглаа боодол” үндэсний хөтөлбөрийн 2018-2020 оны биелэлтийг тайлагнахдаа “Цаасан сав баглаа боодлын үйлдвэрлэл”-ийг дэмжин нэг иргэнд Баянхонгор үйлдвэржилт хөгжлийн корпрациас 70.0 сая төгрөгийн зээлийг 36 хугацаатай хөнгөлөлттэй нөхцөлөөр олгон хамтран ажиллаж байна. Тус төсөл хэрэгжсэнээр аймгийн төвийн нийтийн хоолны газруудын нийлэг уутны хэрэглээг түдгэлзүүлж зөвхөн цаасан уутыг хэрэглэж хэвших” гэсэн биелэлтийг оруулж байгаа ч тус төслийг хэрэгжилтийн явцад газар дээр нь очиж дээрх зорилтыг хангаж байгаа талаар шалгаагүй байна. Харин аудитын явцад газар дээр нь очиж танилцахад тус зээлийг 2017 онд олгосон ба төсөл хэрэгжүүлэгч нь *“Зээлийн хөрөнгөөр 2 тоног төхөөрөмж худалдан авсан ч нэг тоног төхөөрөмжийн тохиргоог хийж чадахгүй байгаа ч цаасан сав, хаяг шошгийг төсөлд тусгаж төлөвлснөөр үйдвэрлэж чадахгүй байгаа ч, бага хэмжээгээр үйлдвэрлэж сүү, цагаа идээний худалдаа хийдэг иргэдэд нийлүүлж байгаа”* гэсэн тайлбарыг өгч байна. Гэвч холбогдох байгууллагуудад энэ талаарх мэдээлэл байхгүй, төслийг төлөвлөсөн хэмжээнд зориулалтын дагуу ашиглуулах талаар арга хэмжээ аваагүй байна.

Иймд цаашид бодлогын баримт бичиг, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг тооцохдоо хэрэгжүүлсэн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийг үнэн зөв, бодит тайлагнаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Аудитаар илэрсэн зөрчилд хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнг сайжруулах, зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах 1 албан шаардлага, 14 заалт бүхий зөвлөмжийг холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

_____оОо_____

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Баянхонгор аймгийн хэмжээний хүнсний хангамжийн нөөцийн талаарх судалгаа хангалтгүй, стратегийн хүнсний нөөцийг бүрдүүлээгүй, хүн амын гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоосоо бүрэн хангаж чадахгүй байна.
2. Хүнсний тухай хуулийн 6.2-д “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан байхад уг журам өнөөг хүртэл батлагдаагүй байна.
3. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр орон нутгийн түвшинд зарим бодлогын баримт бичиг, үйл ажиллагааны хөтөлбөрийг үндэсний хөтөлбөртэй уялдуулж, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлоогүй байна.
4. Засгийн газрын 2017 оны 281 тоот тогтоолоор Баянхонгор аймгийн ус хангамжийн эх үүсвэрийг “Цагдаа, дотоодын цэргийн хамгаалалтад авах улсын онц чухал объектын жагсаалт”-д хамааруулаагүй байгаа нь ард, иргэдийн хүнсний аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байна.
5. Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр төрийн бодлогыг тодорхойлоход төрийн байгууллага, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагын уялдаа, холбоо хангалтгүй байна.
6. Мэргэжлийн хяналтын газрын лаборатори нь нялх балчир хүүхдийн хүнсний бүтээгдэхүүний сорьц шинжилгээг хийх боломжгүй, нормативд заасан бүтэц, орон тоогоор ажиллах нөхцөл бололцоог хангаж өгөөгүй байна.
7. Мал эмнэлгийн газрын лабораторийн барилгын зарим өрөө, тасалгааны дээвэр нь цөмөрч нурсан, стандартын шаардлага хангахгүй байдалд хүрсэн, багаж тоног төхөөрөмжүүдийг шалгалт тохируулгад бүрэн хамруулаагүй байна.
8. Хүнсний үйл ажиллагаа эрхлэгчид дүрэм, журмаар зохицуулсан дотоод хяналтын үйл ажиллагааг бүрэн хийгээгүй, мэдээлэл ойлголт дутмаг байна.
9. Аймгийн хэмжээнд ард иргэд, аж ахуйн нэгжүүдийн хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодлын хэрэглээний талаар нэгдсэн дүн судалгаа байхгүй байна.,
10. Аймгийн хэмжээнд хоолноос хамааралтай өвчлөлийн тоо буураагүй, ард иргэдийн дунд зориулалтын бус хуванцар сав, баглаа боодлын хэрэглээ байсаар байгаа нь түүнийг бууруулах талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь бодит үр дүнгээ өгөхгүй нийтийг хамарсан түвшинд хүрч чадахгүй байна.
11. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө, хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлээгүй, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналтыг оновчтой хэрэгжүүлээгүйгээс төсвийн хөрөнгийн үр ашиг бодитой гарахгүй байна.

_____оОо_____

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:

1. Хүнсний аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг мэргэжлийн холбоод болон бүх талын оролцоог ханган, орон нутгийн онцлог, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь заалтад заасан шаардлагад нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэх.
2. Баянхонгор аймгийн ус хангамжийн эх үүсвэр нь энгийн харуул хамгаалалттай байгаа нь ард, иргэдийн хүнсний аюулгүй байдалд эрсдэл үүсгэж байгаа тул цагдаа, дотоодын цэргийн хамгаалалттай болгох талаар 2022 оны төсөвт тусгах талаар, арга хэмжээ авч ажиллах.
3. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалтыг эрэмбэлэхдээ хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хүний нөөц, барилга байгууламж, тоног төхөөрөмжийн асуудлыг нэн тэргүүнд авч үзэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авч ажиллах.
4. Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасны дагуу аймгийн хэмжээний стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг авч ажиллах.
5. Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр олгож байгаа хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрийг импортын бүтээгдэхүүний зохистой харьцааг хангах дотоодын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх бодлоготой уялдуулан бүх салбаруудад тэгш хүртээмжтэй, оновчтой хуваарилж байх.
6. Сургууль, цэцэрлэгт малын гаралтай хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх нийлүүлэгчтэй байгуулах гэрээнд мал эмнэлгийн итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний хариу болон QR код бүхий гэрчилгээг авч байх гэсэн нөхцөлийг тусгаж байх чиглэл өгч ажиллах.

ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Н.БЯМБАДОРЖ ТАНАА:

1. Хэрэгцээ шаардлагад тулгуурлан лабораторийн хүчин чадал, итгэмжлэлийн хүрээг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ ажиллах
2. Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар холбогдох арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу авч, хяналт шалгалтын үр нөлөө, үр дүнг гаргах.
3. Аймгийн хэмжээний хүнсний үйл ажиллагаа эрхлэгчдийг хүнсний сүлжээний өөрт хамаарах хэсэгт дотоод хяналтыг хэрэгжүүлэх, чанарын удирдлагын тогтолцоог бий болгох, нэгдсэн мэдээллийн сан үүсгэж, зөвлөн туслах хяналт шалгалтыг явуулан мэргэжил, арга зүйгээр хангах.

ГУРАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГА Ж.БАТТӨР ТАНАА:

1. “Ургамлын гарал үүсэл, Пестицидийн бүртгэл хяналтын систем”-ийг иргэн, аж ахуйн нэгжүүдэд сурталчлан таниулах, системд бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж ажиллах.

2. Хүнсний зориулалтын сав, баглаа боодлын хэрэглээ, дотоодын үйлдвэрлэл, хангамжийн талаар нэгдсэн мэдээллийн сан үүсгэж дүн шинжилгээ хийн түүнд чиглэсэн бодлого боловсруулж хэрэгжүүлэх.

ДӨРӨВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА Л.ОЮУН-ЭРДЭНЭ ТАНАА:

1. Мал эмнэлгийн газрын явуулын лабораторийг малын гаралтай бүтээгдэхүүн борлуулж буй зах, худалдааны төвүүдэд ажиллуулж, хүнсний бүтээгдэхүүнд учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гарал үүслийн гэрчилгээг дэвшилтэт технологиор баталгаажуулж буй ажлын цар хүрээг нэмэгдүүлж, ард иргэдэд тус үйл ажиллагааг таниулан сурталчлах ажлыг зохион байгуулах.

ТАВ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА Н.ЭНХЖАРГАЛ ТАНАА:

1. Хүн амын хүнсний бодит хэрэглээ, хангамжийн болон чанар, эрүүл ахуйн төлөв байдал, хүнсний нэр төрөл, найрлага, шим тэжээлийн зохистой харьцаа, цаашид авах арга хэмжээний талаар судалгаа, мэдээллийн сан үүсгэж аймгийн удирдлагыг тогтмол мэдээллээр хангаж байх.
2. Хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах, хүнсний бүтээгдэхүүнд сөргөөр нөлөөлж буй бүтээгдэхүүн, сав, баглаа боодлыг сурталчлан таниулах арга хэмжээний үр дүнтэй зохион байгуулах.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 08 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

_____оОо_____

ҮАГ-ЫН АУДИТЫН ГУРАВДУГААР ГАЗАРТ ХҮРГҮҮЛЭХ САНАЛ:

1. Хүнсний тухай хуулийн 6.2-д “Энэ хуулийн 6.1-д заасан стратегийн хүнсний улирлын нөөц бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална” гэж заасан байхад уг журам өнөөг хүртэл батлагдаагүй байгаа тул холбогдох албан тушаалтанд асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

2. Хот суурины усан хангамж, ариутгах татуургын тухай хуулийн 17.1 -дэх хэсэгт заасан улсын онц чухал объектод хамаарах ус хангамжийн эх үүсвэрийн жагсаалтыг Монгол улсын Засгийн газрын 2017 оны 281 дүгээр тогтоолоор батлахдаа зарим аймгуудын ус хангамжийн эх үүсвэрийг оруулаагүй байгаа тул аймгуудын усны эх үүсвэрийн аюулгүй байдлыг ижил түвшинд авч үзэх асуудлыг холбогдох байгууллага албан тушаалтанд уламжилж, шийдвэрлүүлэх.

3. Орон нутаг дахь лабораторийн бүтэц, орон тоог Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргын тушаалаар баталсан лабораторийн жишиг бүтэц, орон тоонд нийцүүлж бий болгох зөвлөмжийг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлэх.

4. Мэргэжлийн хяналтын газрын лабораторийн шинжилгээний үр дүнг хэвлэн гаргах баталгаажуулах үйл ажиллагаанд үр дүнг хуурамчаар үйлдэх, мэдээлэл алдагдахаас хамгаалагдсан шийдлийг цогцоор шийдэж сайжруулах зөвлөмжийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид хүргүүлэх.

5. Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторид хууль, журмаар хүлээсэн үүргээ бүрэн хэрэгжүүлж орон нутаг дахь сүлжээ лабораториудаа нэгдсэн удирдлага, арга зүйгээр хангаж ажиллах зөвлөмжийг хүргүүлэх.

6. Баянхонгор аймгийн Мал эмнэлгийн лабораторийн орчин нөхцөлийг сайжруулах зөвлөмжийг Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэх.

____оОо____